

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

НОМЫН САН



ШИНЭ НОМЫН

2016.12 сар

№ 07

ЭМХЭТГЭСЭН:

Номзүйч М. Кунай

Номзүйч М. Намжилмаа

Электрон каталог:

<http://catalog.num.edu.mn>


ГАРЧИГ

➤ БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААН	2 - 4
➤ МЭДЭЭЛЭЛ ЗҮЙ	4 - 5
➤ ОЙ СУДЛАЛ	5 - 5
➤ АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААН	5 - 7
➤ НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН	7 - 7
➤ ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН	7 - 15
➤ ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН	15 - 18
➤ УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН	18 - 21
➤ ХУУЛИЙН ШИНЖЛЭХ УХААН	21 - 22
➤ ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААН	22 - 22
➤ БИЕИЙН ТАМИР, СПОРТ	22 - 23
➤ ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ	23 - 23
➤ НОМ, НОМЫН САН СУДЛАЛ	23 - 24
➤ ХЭЛ ШИНЖЛЭЛ	24 - 26
➤ АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ	26 - 27
➤ УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ	27 - 30
➤ УРАН ЗОХИОЛ	30 - 39
➤ УРЛАГ СУДЛАЛ	39 - 41
➤ ШАШИН СУДЛАЛ	41 - 43
➤ ГҮН УХААН	43 - 46
➤ СЭТГЭЛ СУДЛАЛ	46 - 48
➤ ГАДААД ХЭЛ ДЭЭРХ НОМУУД	48 - 50

Товчилсон үгийн тайлбар:

БУН унш-Байгалийн ухааны номын уншлагын танхим /Хич-2, №307/
НУН унш-Нийгмийн ухааны номын уншлагын танхим /Хич-2, №213/
Гад.фонд-Гадаад фонд /Хич-2, №136/
Лав.ф-Лавлагааны фонд /Хич-2, №108/
БС- ийн номын сан /Хич-5, №505., Хич-8/
ОУХНУС-ийн номын сан /Хич-5, №304/
ХЗС-ийн номын сан /Хич-3, №205/
ХШУИС-ийн номын сан /Хич-3, №113/
ШУС-НУС-ийн номын сан /Хич-2, №219/
ШУС-ХУС-ийн номын сан /Хич-2, №334/
ШУС-БУС-ийн номын сан / Хич-1, №110., Хич-3, №221., Хич-7, №115

БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААН



Дашням Б. **Шинжлэх ухаан, 2040 оны биологи: Үүдэл эсийн судалгаа** /Хян. Д.Баярлхагва, С.Ганболд. -УБ.: Адмон, 2016. -91х. -ISBN 99962-55-80-9.

21-р зууны тэргүүлэх чиглэл болох Биологийн шинжлэх ухааны хамгийн шинэлэг, анхаарал татаж буй нь үүдэл эсийн судалгаа юм. Ургамлын үүдэл эсийн эмчилгээ, тэжээлийн бэлдмэл Монгол улсад аль хэдийн нэвтэрчээ. Хүний үүдэл эсийг ашиглан хүний эд эрхтэн бүтээх, эмчилгээгүй гэж бодож байсан олон өвчнийг эмчлэх, харьцангуй урт наслах боломжтой. Энэ номонд үүдэл эс гэж юу болох, цусны үүдэл эс, үүдэл эсийн ертөнц, өсгөвөрлөсөн мах, үүдэл эсийн эмчилгээ хэр зэрэг бодитой вэ? халдварт өвчний тархалтыг зогсоохын тулд “телепортерыг хэрхэн ашиглах вэ?”, биоүйлдвэрийн инноваци, 2040 онд хүн юу эрхлэх вэ? Дэлхий ертөнц ямар байх вэ? талаар өгүүлэх бөгөөд номонд үүдэл эсийн тухай багахан тайлбар толийг хавсаргажээ.

28.05

Д-39


/БУН унш-3, ШУС-БУС-5ш/

T-18327-

18328

Монголын геологи ба ашигт малтмал: 8 боть. /Эрхл. Ж.Бямба. - УБ.: Соёмбо, 2012. -ISBN978-99-962-2-314-3 (Уул Уурхайн Яам, “Эрдэнэт үйлдвэр” ХХК)

Энэхүү цуврал бүтээл нь Монголын газар зүйн байрлалаас эхлээд геологийн судалгааны түүх болон нутаг дэвсгэрийн хэмжээнд судлагдсан тунамал-вулканоген хурдас, интрузив чулуулаг тэдгээрийн тархалт, найрлага, насны үндэслэл болон геологийн бараг бүх насны хурдсанд хадгалагдаж ирсэн палеонтологийн үйлдвэрийн хөгжил, тархалт ба ангилал зэргийг өнөөгийн судлагдсан байдлын хэмжээнд авч үзсэн болно. Монголын нутаг дэвсгэрт тархсан нүүрс, шатах занар, газрын тос, хар, өнгөт, ховор метал ба ховор шороон элемент, уран болон фосфорит, давс, гөлтгөнө, бал чулуу, керамзит, флюорит, гялтгануур хийгээд элс, хайрга, шавар, шохой зэрэг барилгын эрдэслэг материалын болон өнгөт эрдэнийн чулууны орд, илэрлүүдийн байрлал, найрлага, гарал үүсэл, ач холбогдол, хэрэглээ зэргийг авч үзсэн нь чухал ач холбогдолтой бас сонирхолтой болжээ. Ботийг Монголын газарзүйн зураг, Монголын сансарын зураг, Монголын геодинамикийн зураг, Монголын идэвхитэй хагарлын зураг, Монголын соронзон орны гажлын зураг, Монголын нүүрсний орд, шатдаг занарын орд, газрын тосны савуудын байршил зэргийг харуулсан нийт 15 хавсралт зураг (60х90см) дагалдана.



26.34 Б.1: Стратиграфи. -562х.

/БУН-унш-7ш/

T-18479-18481

М-69 Б.2: Палеонтологи.-527х.

/БУН-унш-7ш/

T-18482-18484

Б.3: Интрузив чулуулаг. -463х.

/БУН-унш-7ш/

T-18485-18487

Б.4: Литосферийн плитийн тектоник. -494х.

/БУН-унш-7ш/

T-18488-18490

Б.5: Шатах ашигт малтмал. -394х

/БУН-унш-7ш/

T-18491-18493

Б.6: Метал ашигт малтмал. -364х.

/БУН-унш-7ш/

T-18494-18496

Б.7: Метал бус ашигт малтмал. -325х.

/БУН-унш-7ш/

T-18497-18499

Б.8: Гидрогеологи. -548х.

/БУН-унш-7ш/

T-18500-18502

Ногоон технологи инноваци 2016: Эмхэтгэл /Эмхт.С.Шинэзул; Хян. Г.Нямдаваа. - УБ.:Хан Дизайн, 2016. -91х.

“НОГООН ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИ-2016” зөвлөгөөн дэлхий дахины орчин үеийн хөгжлийн чиг хандлага болж буй ногоон технологи, инновацийн бодлого, стратеги, хөгжлийн тулгамдсан асуудал, олон улсын туршлагын талаар хэлэлцэж, бизнест нэвтрүүлэх боломжтой, байгальд ээлтэй техник, технологи, инновацийн шинэ санаа, шийдлийг бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид, олон нийтэд таниулахад чиглэгдсэн. Зөвлөгөөн, үзэсгэлэнд ногоон хөгжлийн бодлогыг хөгжүүлэх, байгальд ээлтэй техник технологи, оновчтой шийдлийг сурталчлах үүднээс ногоон бизнес эрхлэгчид, шинийг санаачлагчид, ногоон инноваци, технологи хөгжүүлэгчид, эрдэмтэн, судлаачид, бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчдын 150 гаруй төлөөлөл хамрагджээ.




20.1

Н-67

Т-18335-

18337



Пржевальский Н.М. **Монгол орон ба тангудуудын нутаг газар:** 1,2-р боть /Орос. Хэлнээс орч. Ч.Баатар. -УБ.: Адмон, 2013. -728х. -ISBN 978-99962-0-458-6.

Оросын жанжин штабын дэд хурандаа, эзэн хааны газарзүйн нийгэмлэгийн жинхэнэ гишүүн Н.М.Пржевальский Төв Азийн уулархаг их нутаг, уул нуруу, тал хээр, говь цөл, ус мөрөн, ургамал амьтан, араатан жигүүртэн, цаг уур, отог омог, угсаатан ястны амьдрал ахуй, ёс заншил, шашин шүтлэгтэйн гурван жилийн турш шинжлэн судалж, Европ дахинд танилцуулсан аялалын тэмдэглэлийг танилцуулж байна. Эхний ботид Хиагтаас Бээжин, Монгол, Ордос, Алашаа нутаг, Умард Төвөд зэрэг нутгаар аялсан тухай, 2-р ботид цаг уур, шувуу, хэвлээр явагч болон хоёр нутагтан амьтан, загасны талаар өгүүлжээ. Н.М.Пржевальскийн энэхүү бүтээл нь 1875 онд хэвлэгдсэн бөгөөд Оросын болон дэлхийн газарзүй, ургамал, амьтан судлал, угсаатны зүйн шинжлэх ухаанд үлэмж гавьяа оруулсан бүтээл юм.

26.89/1/

П-74

/БУН унш-4, ГНОФ-3, ШУС-ХУС-1ш/

Т-18298-

18300

Соёмбо нэвтэрхий толь: Монгол орны ургамал, амьтан /Ред. Х.Цэдэв,Б.Оюун-Эрдэнэ,Э.Жаргалмаа. -УБ.:Соёмбо, 2016. -448х. - ISBN 978-99962-75-64-7.

Монгол орон өргөн уудам нутагтай бөгөөд байгалийн тогтоц нь олон янз тул өндөр уул, хээр тал, ой мод, говь цөл хосолсоны ачаар амьтны аймаг нь баялаг билээ. Өндөр уул нурууд олонтой тул тэдгээрт босоо бүсшил бий болж, бүс бүслүүр дотор ч амьдрах орчны олон янз байдал илэрдэг тул тэнд олон зүйлийн амьтад байршин амьдрах тохиромжтой нөхцөл бүрэлджээ. Монгол оронд өндөр уулын тагийн бүслүүрээс эхлээд цөлийн бүс хүртэлх бүх бүс бүслүүрийн амьтад тархан амьдардаг онцлогтой. Ургамлын аймгийн судалгаа маш олон хүн эрдэмтдийн хүч, хөрөнгө, хугацаа шаарддаг. Монгол орны ургамлын аймгийн судалгааг 1830-40-өөд оноос Орос, Сибирийн эрдэмтэн, судлаачид, жуулчид эхэлсэн байдаг. Харин 1942 онд МУИС байгуулагдаж дээд мэргэжилтэй ургамал судлаачдыг бэлтгэж эхэлсэн, Зөвлөлт Улсад суралцаж дээд мэргэжил эзэмшсэн мэргэжилтэн залуус эх орондоо 50-иад оны сүүлчээр эргэн ирж, 1969 онд



ШУА байгуулагдсанаар Монгол орны ургамал судлалын ажил улам өргөжсөн байна. Энэхүү бүтээл нь ургамал, амьтны баялагаа танин мэдэх, зохистой ашиглах, цаашдын судалгаа хайх чиг баримжаа болох ач холбогдолтой юм.

28.68я2

С-52

/БУН-унш-3,ГНОФ-3,Лав-1ш/

Т-18376-

18378



Туваанжав Г. ба бус **Аналитик хими ба усны шинжилгээ** /Д. Мөнхзул, Л.Долгоржав ; Хян. Д.Мөнхзул. -УБ.: Адмон, 2016. -304х. - ISBN 978-99973-0-904-4.

Энэ номонд байгалийн усанд зонхилж буй нэгдлүүд, элдэв махбодиуд, тэдгээрийн үүсэл, гарал, хэмжээ дамжаа болон эдгээрийн агууламжийг шинжилж тогтоох, өөрийн орны нөхцөлд хэрэглэх бүрэн боломжтой нарийвчлал сайтай аргуудыг усны дээж авалт ба физик чанар, усны найрлагыг бүрдүүлэгч нэгдлүүд, усанд ууссан хий ба шим бодисууд ба бичил махбодиуд, ус ариутгах арга, усны хэрэгцээний ангилал гэсэн бүлгүүдэд хуваан авч үзжээ. Уг ном нь байгаль хамгаалах салбарт төдийгүй усны шинжилгээ судалгаа хийдэг салбаруудын бүх ажилтан, химичид, энэ чиглэлээр ажилладаг бүх хүмүүст зориулагджээ.

24.1+26.22

Т-63

/ХШУИС-3ш/

Б-24398-

24400

МЭДЭЭЛЭЛ ЗҮЙ

Соёмбо нэвтэрхий толь: Мэдээлэл зүй /Ред. Э. Жаргалмаа. - УБ.:Соёмбо, 2015. -516х. -ISBN 978-99962-2-960-2.

Мэдээллийн зуунд хүн төрөлхтний бүтээсэн мэдлэгийн ихэнх хэсэг нь тоон хэлбэрт шилжиж, тэдгээрийг хүмүүс компьютерээр боловсруулж, мэдээллийн сүлжээгээр дамжуулан, дэлхийн аль ч өнцөг буланд хүргэх болжээ. Бичвэр, зураг, фильм, аудио бичлэг зэрэг өмнөх үеийн хуримтлуулсан асар их хэмжээний мэдээллийг аажмаар тоон хэлбэрт шилжүүлсээр байна. Уг нэвтэрхий тольд мэдээллийн кодчлол, алгоритм ба програм, програмчлалын онол, програмчлалын хэл, мэдээлэл хадгалалт ба боловсруулалт, компьютерийн үйлдлийн систем, интернет, компьютерийн үүсэл хөгжил, оюуны үйл ажиллагааны автоматжуулалт зэрэг ойлголтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг багтаажээ.


32.973я2

С-52

/БУН-унш-3,ГНОФ-3,Лав-1ш/

Т-18388-

18390



Уянга С. **Системийн шинжилгээ ба зохиомж:** Их дээд сургуулийн сурах бичиг /Хян. Б.Нэргүй, П.Оюунбилэг. -3 дахь хэвлэл. -УБ.: Бит пресс, 336х. - ISBN 978-99962-65-72-3.

Их, дээд сургуулийн компьютерийн ухаан, мэдээллийн технологийн сургалтанд зориулагдсан энэхүү сурах бичиг нь 5 бүлэгтэй ба мэдээллийн системийн хөгжүүлэлт, системийг хөгжүүлэх цикл, төрөл, системийн төслийн удирдлага, системийн шинжилгээний хамрах хүрээ,

мэдээллийн шаардлагын шинжилгээ, өгөгдлийн толь бичиг, процессийн шинжилгээ, системийн зохиомж, интерфэйсийн зохиомж, эргономикийн зохиомж, программ хангамж хөгжүүлэлт, системийн туршилт ба хэрэгжүүлэлт, аюулгүй байдал зэрэг асуудлуудыг дэлгэрэнгүйгээр авч үзжээ.

32.973-018.2я73

У-71

/БУН унш-4, ГНОФ-3, ХШУИС-10ш/


Б-24366-

24368

ОЙ СУДЛАЛ

Монголын хөрс судлал 2016 (01) УБ.:Удам соёл, 2016. -186х. -ISBN 978-99973-48-95-1

(Хөрс судлалын холбоо, ШУА Газарзүй-Геоэкологийн хүрээлэн Хөрс судлалын салбар, Монгол Улсын Их Сургууль, ХААИС-ийн Агроэкологийн сургууль, Дарханы Ургамал Газар тариалангийн хүрээлэн, Ховд их сургууль)




Монголын хөрс судлаачдын анхдугаар чуулга уулзалтанд олон салбарын төлөөлөл болох 70 гаруй эрдэмтэн судлаачид хамрагдаж их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд болон судалгаа шинжилгээний байгууллагуудад ажилладаг ахмад эрдэмтэн, судлаачид болон залуу судлаачдын 20 гаруй илтгэл, 5 үзүүлэн илтгэл тавигдсан ба эдгээр илтгэлүүдийг эмхтгэн гаргажээ. Эдгээр илтгэлүүдэд Монгол орны хөрсний судалгааны түүхэн хөгжил, хөрс судлалын цаашдын хөгжил, чиг хандлагын талаар мөн хөрсний бохирдол, цөлжилт, хөрсний нөөцийг хамгаалах ба тогтвортой менежментийн тухай дэлгэрэнгүй авч хэлэлцжээ.

40.3

М-69

/ХШУИС-10ш/

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААН



Монгол домчийн судар /Бэлт. Д.Энхтайван, Х.Мөнхбат, Ц.Болормаа; Хян. Х.Алтайсайхан, Ж.Хишигжаргал, Л.Дуламсүрэн, С.Наранчимэг, Аянгат. -УБ.:2016. -808х. -ISBN 978-99973-75-99-5.

Монголын аарцаг нурууны бариа заслын холбооны тэргүүн, анагаах ухааны докторант Д.Мягмарсүрэн гэмтэл согогийн мэс засалч эмчийн ажил хийж байгаад сүүлийн хориод жил Монгол эмнэлгийн сав орчлын бариа засал буюу аарцаг нурууны бариа засал хийж байна. Энэ бүх хугацаанд хүмүүний бие махбодод зонхилон тохиолдож байгаа өвчний талаар судалж амьдрал дээр эдгэж байгаа болон эдгэхгүй байгаа өвчний талаар нэлээд ажиглаж, олон олон өвчтөний биеийг аарцаг нурууны бариа заслаар эдгээж илааршуулсан боловч бас эдгээж чадаагүй тохиолдол байдгаагүйсгээгүй. Харин тэрээр сүүлийн гурван жилийн туршид энэ мухардлаас гарах арга замыг олж харав. Энэ зам бол Монголчуудын өнө эртнээс тахин шүтэж ирсэн Тэнгэр үзэл, Тэнгэр шүтлэгтэй холбоотой. Учир нь Монгол өвгүдийнхөө, Онгод дээдсүүдийн ярианаас Монгол анагаах ухааны онол, тал хээр нутагтаа олон зуун мянганыг угтаж, үдэж амьдрахдаа тэдний ажиглаж, хурааж, өвлүүлж авсан эрдэм чадал, хүнийг эмчлэх арга барил нь ямар аугаа болохыг гайхан бишрэхгүй байхын аргагүйг энэхүү номноос тодорхой харагдана.

53.59

М-69

18391

Т-

Өнөрсайхан С. **Хүнсний химийн шинжилгээний аргууд** /Хян. С.Хүрэлбаатар. -2 дахь хэвл. -УБ.: ВСИ., 2011. -140х. -ISBN 978-99929-64-39-1.



Хүнсний эрүүл ахуй, хүнсний хими, хүнсний технологи, хоол судлалын чиглээр суралцаж буй их дээд сургууль, тусгай мэргэжлийн коллежийн оюутнууд, эрдэм шинжилгээ, хүнсний үйлдвэр, лабораторийн ажилтнууда зориулагдсан энэ номонд хүнсний бүтээгдэхүүний найрлагыг бүрдүүлэгч үндсэн нэгдлүүд, тэдгээрийг тодорхойлох арга, сав баглаа боодол, мах, сүү, хүнсний тос, гурилыг шинжлэх эрүүл ахуйн шинжилгээ мөн ХАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүнд хийгдэх ариун цэврийн шинжилгээний аргуудын талаар дэлгэрэнгүй өгүүлжээ. Лабораторид шаардлагатай багаж, хэрэгслийн жагсаалт, шинжилгээнд хэрэглэгдэх уусмал бэлтгэх аргачлал, хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах хүнд метаал болон пестицидийн үлдэгдлийн хүлцэх хэм хэмжээг хавсралт хэсэгт оруулж өгчээ.


51.23

Ө-83

/БУФ-5, БУС-2ш/

T-18421-

18423



Эх үрийн судар /Эмхт. Ц.Наранханд; Хян.Аянгат УдГүн, Д.Довчинсүрэн. -УБ.:Хөх судар, 2016. -196х. -ISBN 978-99962-64-32-0.

Голчлон ардын болон домын аргуудын тухай түлхүү өгүүлсэн энэхүү судрыг бөөгийн ухаанд шамдан буй улаач нар тэртээх эрт амьдарч байсан Өвгүд, Эмгүдийн сүнснээс өртөөлөн сонирхуулж буйгаараа онцлогтой. Энэ ном улаач хүмүүн онгодоо буулган айлдвар сургаалийг нь сонсож, тэмдэглэж аваад эртний Монгол хэлнээс өнөөгийн залуус ойлгох хэмжээнд өөрийн санаагаар орчин үежүүлэн бичсэн ба эхлээд настай хүний захиас мэт, тэгснээ эмчийн зөвлөгөө мэт холимог сэтгэгдэл төрүүлсэн, сонирхолтой, амьдралд хэрэгтэй, төрөх насны эхчүүдийн мэдэж байвал зохих мэдээлэл сургаалиудыг нэгтгэж, тайлбарласан өвөрмөц бүтээл болжээ.

51.19(1)4

Э-98

Б-24423-

24424

Юндэн С. **Химийн бодисын эмнэлзүйн хор судлал**: Сурах бичиг /Хян. С.Өнөрсайхан. -УБ.: Эзэн сүлд, 2014. -358х. -ISBN978-99973-40-53-5.



Энэ номонд манай орны анагаах ухааны практикт үйлдвэрлэлийн болон ахуйн химийн ослын хэлбэрээр тохиолддог зарим бодисын талаар дэлгэрэнгүй бичжээ. Үүнд хортой бодис гэж юу болох, хордлого тайлах эмчилгээний аргууд, эмийн ба төрөл бүрийн химийн бодисын хордлого, ургамал амьтны хорт бодис болон чонон хөрвөс зэрэг хордлогот харшлын өвчнүүдийн талаар эрчимт эмчилгээний эмч, мэргэжилтэн, оюутан нарт гарын авлага болох ажээ. Мөн бүлэг бүрийн төгсгөлд тухайн мэдлэгийг шалгах асуултуудыг хавсаргаж өгчээ.

52.84

Ю-50

/БУН унш-5, БУС-2ш/

T-18424-18426

НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН



Вүүлф В. **Өөрийн гэсэн өрөө** /Англи хэлнээс орч. Т.Ариунсанаа; Ред. Б.Сувддулам. -УБ.:Монсудар, 2016. -207х. -ISBN 978-99973-1-365-2.

Монгол хэлнээ анх удаа орчуулагдаж буй энэхүү эссэг феминизм, эмэгтэйчүүдийн эрхийн хөдөлгөөний тухай чухал лавлагааны материалд тооцсоор ирсэн юм. *Өөрийн гэсэн өрөө эссэ* нь, *Виржиниа Вүүлфийн* 1928 оны аравдугаар сард Кэмбрижийн их сургуулийн, зөвхөн эмэгтэйчүүд суралцдаг Гиртон, Ньюнхэм хэмээх хоёр сургуульд уншсан “Эмэгтэйчүүд ба утга зохиол” хэмээх цуврал лекцээс ургаж гарчээ. Вүүлф лекц уншсанаасаа хойших хэдэн сард эссэгээ улам бүр баяжуулж, 1929 онд бие даасан ном болгож хэвлүүлсэн байна.

60

В-88

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24507-24509

Монгол Улсын Статистикийн эмхэтгэл-2015 /Эмхт С.Мэндсайхан, Р.Содхүү, А.Дэмбэрэл, Х.Бажийхүү. -УБ.: 2016. -413х. -ISBN 978-99973-3-886-0. (Улсын Бүртгэл, Статистикийн Ерөнхий Газар)

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн 2015 оны эмхэтгэлийг өмнөх гурван жилийнхтэй харьцуулан тухайн жилд хийгдсэн томоохон тооллого, судалгааны үр дүн, шинээр нэмэгдсэн зарим үзүүлэлтээр баяжуулан толилуулж байна. Статистикийн эмхэтгэлийг хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй болгох зорилгоор үзүүлэлтийг тооцох аргачлал, нэр томъёоны тайлбар, тухайн салбарын онцлох мэдээллийг бүлэг бүрийн өмнө тодотгож, нийгэм, эдийн засгийн салбаруудын таних тэмдгийг байршуулжээ.

60.6(1)


М-69

/НУН-унш-4,ГНОФ-3,ШУС-НУС-10,Цахим-1ш/

Т-18403-18405



ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН



Бариянжав П. **Мянгадын түүх** (XIII-XX зууны 30-аад он) /Ред. На.Сүхбаатар. -УБ.:Соёмбо, 2016. -512х. -ISBN 978-99962-65-74-7.

Монголын олон ястан үндэстний гарал үүсэл, угсаа-түүхийг судлах нь манай түүхийн шинжлэх ухааны нэгэн чиглэл, зорилт нь юм. Өнөө хир баруун, төв, дорнод монголд олон угсаатны бүлгүүд оршин сууж байгаагийн дотроос Баруун монголд бүр ч олон угсаатны бүлгүүд байдаг. Үүнд: Мянгад, Урианхай, Дөрвөд, Баяд, Өөлд, Захчин, Торгууд, Хотон, Хошууд, Халх, Хасаг, Тува, Уйгар зэрэг том, жижиг ястан угсаатны бүлгүүд бий. Эдгээр угсаатны бүлгүүд түүхийн урт удаан хугацаанд амьдран ирсэн тэмцлийн дайчин баатарлаг зам мөр, уйгагүй нөр их хөдөлмөрийнхөө буурал түүхээ бүтээсээр ирсэн билээ. Бодит үнэн баримттай, бас хойших үеийнхэндээ сургамжтай, дайчин түүхээ зам гудас гэж бүдгэрүүлэх, мартахгүйн тул ястан үндэстэн бүр хүчин чармайж түүх шаштираа бичиж, хойч үедээ өвлөн өгч хадгалуулсаар ирсэн сайхан зам мөр бидэнд бий.

63.3(1)


Б-29

/НУН-унш-3ш/

Б-24460-24461

Батсүрэн Б. **Ухуань(Авар) ба Сянь(Сэрби)** /Хян. С.Өлзийбаяр. -УБ.: ТЭПЭ, 2016. -168х. -ISBN 978-99973-52-51-4.

Монголын эртний түүхэнд тод ул мөр үлдээсэн эртний нүүдэлчдийн нэг бол Дунху болон түүний удмын ухуань ба сяньби нар юм. Ялангуяа сяньби нар Хүннү улсыг залган Монгол нутагт ноёрхлоо тогтоож өөрсдийн төр улсыг байгуулж тус оронд нутаглах нүүдэлчдийн түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзсээр ирсэн. Ухуанийг эрдэмтэд Авартай холбоотойг тогтоосон байна. Харин сяньби нарыг Шивэй аймгуудын өвөг гэж бичдэг бөгөөд энэ бүтээлд эдгээр асуудлыг судлаж нягтлажээ.



63.3/1/

Б-34

/НУН унш-4, ГНОФ-3, ШУС-ХУС-10ш/

Б-24395-24397



Вернадский Г.В. **Монголын эзэнт гүрэн** /Орос хэлнээс орч. Ч.Баатар. - УБ.: Монсудар, 2014. -167х. -ISBN 978-99973-1-156-6.

Г.В.Вернадский/1887-1973/ бол Евразийн үзлийг үндэслэгчдийн нэг ба нэрт түүхч, соёл судлаач юм. Түүний энэхүү бэсрэг бүтээлд Их монгол улсын эзэнт гүрний засаг захиргаа, цэргийн бүтэц, зохион байгуулалт, “их засаг” хууль цаазын онцлог, шинж чанарыг мөн түүнчлэн Гүюг, Мөнх, Хубилай зэрэг Монголын хаадын амьдрал үйл ажиллагааг товч боловч бодитой авч үзэж, шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэлт дүгнэлт өгчээ. Вернадский “Монголчуудын эзэгнэл голлон эерэг нөлөө үзүүлж, Орос орон нэгдсэн удирдлага тогтолцоонд орж, төвлөрсөн том гүрэн улс болж төлөвшсөнийг онцлон тэмдэглэжээ.

63.3/1/41

Б-35

/НУН унш-4, ГНОФ-3, ШУС-ХУС-2ш/

Б-24389-24391

Гомбосүрэн Ц., Дагзмаа Б. **Орчин үеийн Монгол дахь түүхийн бүтээлүүдэд болон түүхэн романуудад Өндөр Гэгээн Занабазарт өгсөн үнэлгээнд холбогдох философи тайлбар** /Тех.ред. Г.Ганзориг; Бэлт. Б.Дагзмаа. -УБ.:Артсофт, 2016. -122х. -ISBN 978-99973-53-69-6.

Уг бүтээл нь түүхийн мэдлэгийн талаарх философи үнэлэмжийн хэв маягууд, Өндөр Гэгээн Занабазарын гадаад бодлого, үйл ажиллагаанд орчин үеийн Монголын түүхчид өгдөг үнэлгээ, Монгол романууд дахь Өндөр Гэгээн Занабазарын дүр, Монголын түүхийн мэдлэгийн агуулгад постструктуралист, постмодернист тайлбар өгөх нь зэрэг агуулгыг багтаасан. Түүхэн баримт, үйл явдлын тухай, түүний дотор түүхэн бие хүний амьдрал, үйл ажиллагааны тухай мэдлэгийн агуулга нь баттай үнэн байх болоцоо хязгаарлагдмал байдгийг Өндөр гэгээн Занабазарын талаарх түүхийн судалгааны янз бүрийн тайлбарт болон түүхэн романууд дахь өөр өөр үнэлгээнд тулгуурлан орчин үеийн философийн зарим үндэслэлийн үүднээс товч илэрхийлжээ.

63.3(1)

Г-53

/НУН-унш-4,ГНОФ-3,ШУС-ХУС-5ш/

Б-24405-24407



Гумилев Н.Л. **Хүн гүрэн**: Тал нутгийн тухай гурвал /Ред.Д.Мөнхцэцэг; Орч.Б.Даш-Ёндон. -2 дахь хэвл. -УБ.: Адмон, 2015. -238х. -ISBN 978-99962-0-383-1.

Энэ номонд хүчирхэг дайчин чанар, аж төрөх байдлаараа Евразийн хувь заяанд асар их нөлөө үзүүлсэн хүн зоны амьдралыг нэн сонирхолтойгоор туурвин гаргажээ. Модун нутаг дэвсгэр бол төр улсын үндэс гэсэн үзэл баримтлал тогтоон мөрдөж, хүн бүр цэргийн алба хаах, даргадаа үг дуугүй захирагдах хийгээд албан тушаалын тогтолцоо



буй болгосон нь цоо шинэ этносыг бүрдүүлсэн юм. Тиймдээ ч мөхөж сөнөх гэж байсан эртний хүнчүүд Модун Шаньюйн шинэчлэлтийн үр дүнд хүчирхэг цэргийн гүрэн болж бэхжсэн аж. Энэ мэтчилэн нүүдэлчдийн анхны төрт улс болох Хүн гүрэн /Хүннү/-ийг байгуулагчдын өвөг дээдэс, газар нутаг, хүчирхэгжиж байсан үе, зөрчил тэмцэл, мөхөл зэргийг маш тодорхой, сонирхолтой байдлаар бичсэн энэхүү ном нь Монголчууд өөрсдийн үүх түүхээ сайтар ойлгоход ихээхэн тус болох юм.

63.3(5)

Г-73

/НУН унш-4, ГНОФ-3, ШУС-ХУС-1ш/

T-18332-18334

Дорж Т. **Эзэн Чингис хааны удирдахуйн удис** /Ред. Т.Намжим, Д.Цэрэнсодном. -УБ.: Соёмбо принтинг, 2016. -248х. -ISBN 978-99973-49-97-2.


Зохиогч “Монголын нууц товчоо”, “Судрын чуулган”, “Алтан товч” болон бусад түүхийн эх сурвалжуудад тулгуурлан Чингис хааны удирдах удисын тухай энэ номонд өгүүлжээ. Их эзэн Чингис хааны удирдах удисыг Чингис хаанд удирдахуйн шинжлэх ухаан бүрэлдэн төлөвшихөд нөлөөлсөн орчин хүчин зүйл, түүний удирдахуйн бодлого, бүтэц, агуулга, Их Монгол улсын төр, түүний үйл ажиллагаа, удирдахуйн мотиваци, манлайлал, дайн байлдааны удирдахуйн урлаг, түүний удирдах урлаг ба эрин үе, Монголын менежментийн философи загварыг томъёолохуй гэсэн 7 бүлэгт хуваан авч үзжээ.

63.3/1/41

Д-54

/НУН унш-3, БС-5ш/

T-18435-18436



Майский И.М. **Монгол орон хувьсгалын босгон дээр** /Ред.Д.Мөнхцэцэг; Орос хэлнээс орч. Ч.Баатар. -УБ.: Монсудар, 2015. -293х. -ISBN 978-99973-1-145-0.

"МОНСУДАР" хэвлэлийн газраас эрхлэн гаргаж буй “Монголоор бэдэрсэн гадныхан” цуврал бүтээлийн дараагийн боть болох уг номонд И.М.Майскийн 1919-1920 онд Монголд ажиллаж нийтдээ 3000 орчим километр замыг туулсан аялал, Хоршоодын төв холбооны Эрхүүгийн конторын багийнханы цуглуулсан мэдээллүүд багтаснаас гадна нийгэм эдийн засаг, байгаль цаг уур, мал аж ахуйн талаар урьд өмнө нь хэвлэгдэн гарсан бүтээлүүдийг нэгтгэн, анх удаа Монголын хүн ам болон малын тоог статистик аргаар боловсруулан гаргаснаараа онцлог бөгөөд ХХ зууны монголын түүхийн нэгэн чухал эх сурвалж юм. Уг бүтээл нь Монголчуудын ахуй амьдрал, түүх соёлыг сонирхон судлагч эрдэмтэн судлаачид, түүхийн чиглэлээр суралцагч оюутан залуус хийгээд түүх сонирхогч хэн бүхэнд зориулагдсан болно.

63.3(1)

М-14

/НУН унш-4, ГНОФ-3, ШУС-ХУС-1ш/

T-18304-18306

Монгол товчион түүхийн тайлал / Бэлт. Д.Энхтайван, Х.Мөнхбат. -УБ.: 2016.-1460х. -ISBN 978-99973-75-00-1.

"Монгол Товчион Түүхийн Тайлал" хэмээх энэхүү судар нь Монгол Улс сэргэн мандаж орон зайндаа эзэн болсон түүхийг өчүүхэн ч атухай үнэн дүртэй өгүүлсэн судрыг

шасдирыг дэлхийн монголчуудын гарт бариулж, мэлмийд толилуулсан Оросын тэр санваартан Палладий Кафаровын талаар судалгааны бүтээл хураан тэмдэглээд, урьд өмнө нь монгол хэлээр орчуулагдаж байгаагүй дөрвөн бүтээлийг төрөлх хэлнээ буулгаж дуусаад эрхэм уншигч та бүхний гар дээр тавьж байна. Номын нэгдүгээр хэсэгт Пётр Иванович Кафаровын намтар, амьдралынхаа ажлаар холбогдож байсан монголч эрдэмтдийн тухай, МНТ-г улс үндэстнүүдийн хэлээр анх удаа хөрвүүлсэн их гүүш нарын тухай оруулжээ.

63.3(1)-8

Н-93

/НУН-унш-3ш/

Б-24427-24428

Оссендовски Ф. **Хүн, Араатан, Бурхад** /Орч. Ж.Нэргүй; Бэлт. Б.Баярбаатар. -6 дахь хэвл. -УБ.:Жиком, 2014. -299х. -ISBN 978-99973-44-49-6.




Зохиолч Оссендовски 1878 оны тавдугаар сарын 27-нд одоогийн Беларусь Улсын Витебск хотод төрсөн. Польш үндэстэн, Оросын хувьсгалч, зохиолч, нийгмийн зүтгэлтэн. 1905 оны Оросын анхны хувьсгалд идэвхитэй оролцсоныхоо төлөө 1907 он хүртэл улс төрийн цөллөгт байсан. 1909 онд хаант засгийн шорон гяндангийн тухай "Хүмүүсийн тоос" хэмээх роман бичиж хэвлүүлсэн боловч хураагдсан. Октябрын хувьсгалыг эсэргүүцэгч байсан. 1922 онд Америкт анх хэвлэгдсэн Монголын тухай "Хүн, араатан, бурхад" номоороо дэлхийд алдаршсан. 1930 онд хэвлэгдсэн "Ленин" номыг нь Европын хэд, хэдэн оронд хураан шатаасан. Дэлхийн Хоёрдугаар дайны жилүүдэд фашизмын эсрэг Польшийн эсэргүүцлийн хөдөлгөөнд идэвхитэй оролцож явсан. Энэхүү номын агуулга нь Богд гэгээн, Дилав хутагт, Дамбийжаа, Барон Унгерн, Шамбалын орон, Загастайн савдгийн тухай хүүрнэл хийгээд Улаан коммунизм 71 жил тогтоод унах тухай хожим биеллээ олсон зөгнөлийг үлдээсэн 1921 оны аян замын эргэцүүлэл-тэмдэглэл юм.

63.3(1)

О-51

/НУН-унш-3ш/

Б-24411-24412



Д'Оссон К. **Монголчуудын түүх**: Боть I: Чингис хаанаас Тамерлан хүртэл /Ред. Д.Мөнхцэцэг; Орч. Ч.Баатар. -УБ.: Монсудар, 2015. -281х. -ISBN 978-99973-1-154-2.

Д'Оссоны энэ бүтээл нь 4 ботиос бүрдэх бөгөөд энэхүү 1-р ботид эх сурвалж, он дарааллын бичгүүдийн түүхзүйн тойм, Төв Азийн нүүдэлчин угсаатан ястнуудын ерөнхий тойм, Монголын эзэнт гүрэн байгуулагдаж эхэлсэн үе ба бүрэлдэн тогтсон үйл явц, Чингис хааны үйл амьдрал, түүний байлдан дагуулалт зэрэг багтаж, Монголын байлдан дагуулагчийн болон түүний байгуулсан эзэнт гүрний тодорхойлолтоор төгсчээ. Мөн Төв азийн нүүдэлчин ард түмэн, Монголчуудын эртний домог хууч яриа, Хуралдай, Чингис хаан Монголдоо ирсэн нь, Хорезмын эзэнт гүрний тухай, Зэв, Сүбэдэй нарын аяллын үргэлжлэл гэх мэт сэдвүүдийг дэлгэрэнгүй багтаасан байна.

63.3(1)

Д-56

/НУН унш-4, ГНОФ-3, ШУС-ХУС-1ш/

Т-18307-

18309

Рамстедт Г. Й. **Дорно этгээдэд долоон удаа**: Черемис, Халимаг, Афганистан, Туркестан, Монголоор аялсан тэмдэглэл 1898-1912 /Англи хэлнээс орч. М.Саруул-эрдэнэ; Хян. Ж.Урангуа. -УБ.: Сэлэнгэпресс, 2016. -234х. -ISBN-978-99929-2-211-8.

Рамстедтын энэхүү бүтээл анх фин хэлээр 1944,1946 онд 244 тал, фото болон газрын зургийн хамтаар, дараа нь 1953, 1961 онуудад хэвлэгдсэн ба сүүлчийн бүлэгтээ Рамстедт олон монгол дууны орчуулга багтаажээ. Харин энэ ном нь Жон Крюгерийн англи хэлнээ орчуулан, 1978 онд хэвлүүлсэн номны орчуулга юм. Рамстедтын аялал тэмдэглэл нь зөвхөн хэл шинжлэл, утга соёл судлал төдийгүй түүхийн чухал ач холбогдолтой бүтээл ажээ.




63.3/1/

P-21

/НУН унш-3ш/

Б-24541-24542



Сайшаал Б. **Чингис хааны товчоон**: 2 дэвтэр /Кирилл үсэгт хөрв. Ш.Чоймаа, М.Баярсайхан, С.Батхишиг. -УБ.: Соёмбо, 2010. -ISBN-978-99929-4-662-8.

Өвөр Монголын эрдэмтэн Сайшаал 20 гаруй жилийн өмнө Чингис хаан болон түүний түүхтэй холбогдох бүхий л мэдээ сурвалж, дурсгалт бичиг хийгээд монгол, хятад, япон, орос хэл дээрх судалгааны 210 гаруй бүтээлээс нягтлан энэхүү “Чингис хааны товчоон” хэмээх номыг хэвлүүлжээ. Энэхүү зохиол нь Чингис хааны тухай урьд өмнө нь гарсан зохиолын дотроос хамгийн дэлгэрэнгүй том зохиол болсон ба Чингис хааны Монгол болоод дэлхий дахины түүхэнд гүйцэтгэсэн түүхэн үүрэг, эзлэх байр суурийг үнэн зөвөөр тайлбарлажээ. 1-р дэвтэрт Чингис хааны бага, залуу нас, Монгол улсыг нэгтгэж, Их Монгол улс байгуулж бэхжүүлж өргөтгөсөн үе, 2-р дэвтэрт Чингис хаан өмнө, баруун дайлсан, Тангуд улс мөхөж Чингис хаан нас барсан тухай, мөн Чингис хааны хатад, хүргэд, залгамж үеийн холбогдолтой материалууд, ашигласан ном хэвлэлийн жагсаалтын хавсралтууд оржээ.

63.3/1/41

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Дэвт.1. -533х.

Б-24570-24572


C-18

Дэвт.2. -458х.

Б-24573-24575

Сампилаа дурсахуй /Эмхт. Б.Катуу; Ред. А.Алимаа. -УБ.:Соёмбо, 2015. -220х. -ISBN 978-99973-77-53-1.(Монгол Улс Шинжлэх Ухааны Академи Хэл Зохиолын Хүрээлэн)


Монгол улсын шинжлэх ухаанд ХХ зууны дунд үеэс Өрнийн арга зүй, технологийн дэвшлийг эзэмшин Дорнын уламжлалт соёлоо шинээр нээн судлаж, ард түмнээ дэлхийн хөгжилд түүчээлсэн эрдэмтэн сэхээтний нэгэн үе түүхийн захиалгаар төрөн гарсан билээ. Хорлоогийн Сампилдэндэв бол энэ үеийнхний нэгэн тод томруун төлөөлөгч юм. Энэ номд Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, академич Хорлоогийн Сампилдэндэвийн анд нөхөд, эрдэмтэн судлаачид, шавь нар болон гэр бүлийн дурсамжийг эмхэтгэн нийтлүүлжээ. Дурсамжид нэрт эрдэмтнийг хувь хүний талаас болон түүний туурвил бүтээл, ном зохиол, удирдах авьяас зэрэг олон талаас нь үнэлж цэгнэн өгүүлсэн байна.



63г

C-25

T-18503



Саруул-эрдэнэ М. **АНУ-ын монгол судлаачид** /Хян. Ц.Наранцэцэг. -УБ.: Мөнхийн үсэг, 2015. -192х. -ISBN99973-2-820-5.

Зохиогч өөрийн биеэр уулзаж ярилцлага авсан, амьдрал уран бүтээлийг нь үзэж, ажиллаж байсан газруудыг нь нүдээр үзэж танилцсан, АНУ-ын монгол судлаач Уиллиам Вүүдвилл Рокхилл, Оуэн Латтимор, Николас Поппе, Франсис Вүүдмэн Кливез, Антон Мостэрт, Денис Синьор,

Хангины Гомбожав, Жон Крюгер, Хэнри Шварц, Хар Дорж, Кристофер Этвуд нарын амьдрал, намтар, уран бүтээлийн талаар энэ номонд өгүүлжээ.
63.3/С-36 Б-24543-24545

Соёмбо нэвтэрхий толь: Дэлхийн түүх /Ред. Х.Цэдэв, Б.Оюун-Эрдэнэ. -УБ.:Соёмбо, 2012. -659х. -ISBN 978-99962-2-061-6.


Уг нэвтэрхий толиос та эртний хүмүүсийн үүслээс авахуулаад неандарталь хүн, оюун ухаант хүн, урлагийн үүсэл, мал аж ахуй, гар үйлдвэр, овог аймаг, оюуны соёлын үүсэл хөгжил, Эртний дорно дахины улсууд болох Шумер, Вавилон, Эртний Египет, Финикийн хот улсууд, Эртний Иран, Энэтхэг, Япон, Хятад, Грек, Ром зэрэг улсууд, Дундад зууны улсууд болоод шинэ ертөнцийг нээсэн тухай, Византийн ертөнц, Төв Азийн нүүдэлчид, Шинэ цагийн Европ ба Америк гээд бүхий л цаг үеийн улс орнуудын түүхийн талаарх сонирхолтой мэдээ, мэдээлэл олж унших болно.

63.3(0)я2

С-52

/НУН-унш-3, ГНОФ-3, ШУС-ХУС-2, Лав-1ш/

Т-18382-18384



Торновский М.Г. **Монголчуудтайгаа бол би Лиссабон ч хүрнэ** /Бэлт. Б.Баярбаатар; Орч. Ж.Нэргүй. -УБ.:Жиком, 2013. -250х. -ISBN 978-99929-58-67-7.

Иргэний дайны гол удирдагчдын нэг барон Роман Феодорович фон Унгерн-Штернбергийн хувь заяаны цадиг болбоос нийгмийн хөгжлийн зөвлөлт маягийн загварыг эсэргүүцэн, Евразийн улс орнуудад уламжлалт нийгмийн байгуулал хийгээд эзэнт гүрнийг сэргээн босгох гэсэн үзэл бодлын гэрч болон мөнхөрчээ. Хэдийгээр түүний энэ төлөвлөгөө биелээгүй ч, геополитикийн асар холын үр дагаврын суурийг тавьж, их түүхийн хуудсанд арилшгүй мөрөө үлдээсэн юм. Түүний хувь заяаны тухайд саяхныг хүртэл дэлхий нийт 1920-иод оны үед Орос-Зөвлөлтийн Социалист Бүгд Найрамдах Улсын хүрээнд бий болгосон захиалгат мэдээллийг баримталж байсан гэхэд болно. Анх удаа хэвлэгдэж буй энэхүү дурсамж эрхэм уншигчдад Р.Ф.Унгерныг цоо шинээр ойлгоход ихээхэн дөхөм болно хэмээн найдаж байна.

63.3(1)-8

Т-52

Б-24408-24410

Чулуунбаатар Л. ба бус. **Монголын хураангуй түүх:** Хялбаршуулсан сурах бичиг /Б.Лааган, Д.Дашдэлэг. -УБ.: МУИС-ийн хэвлэх, 2016. -246х. -ISBN: 978-99973-42-93-5.

Энэхүү хамтын бүтээлд монголын түүхийг НТӨ XVIII зууны үеэс буюу Хүннү улс анх байгуулагдсан үеэс эхлэн өгүүлэх бөгөөд монголын түүхийн үндсэн асуудлуудыг бие дааж, гүнзгийрүүлэн үзэхэд зориулан, онол арга зүйн зангилгаа асуудлуудыг авч үзжээ. Оюутан, суралцагчид, түүх сонирхогч нарт зориулагдсан энэхүү хялбаршуулсан сурах бичгийн бүлэг бүхэнд асуулт даалгавар, бие даалтын чиглэлийг гаргаж, цаашид дэлгэрүүлэн нэмж уншвал зохих ном зохиолын нэрсийн жагсаалтыг оруулжээ.

63.3/1/я73

Ч-89

/НУН унш-4, ГНОФ-3, ШУС-НУС-5ш/

Т-18437-18439





Шүрхүү Д., Энхчимэг Б. **Монголын хятад судлал: Аман түүх** /Ред. Д.Шүрхүү, Ши Жиюй. –УБ.: Бэмби сан, 2016. -329х. -ISBN: 978-99962-52-51-8.

Орчин цагийн Монгол дахь Хятад судлалын хөгжил хувьсал өөрчлөлтийг харуулж чадахуйц ахмад, дунд насны хятад судлаач Л.Маналжав, Ц.Базаррагчаа, Д.Чулуунцэцэг, Ж.Баясах, Н.Ариунгуа, М.Чимэдцэеэ, Д.Баярхүү, Ч.Батцэцэг, Я.Ганбаатар, Д.Шүрхүү, Д.Болдбаатар, В.Батмаа, Г.Цогзолмаа, Г.Элдэв-очир нарын 14 мэргэжилтэнүүдтэй хийсэн ярилцлагыг энэ номонд оруулжээ. Мөн түүнчлэн тухайн судлаачын хөрөг зураг, товч намтар, бүтээлийн жагсаалтыг оруулж өгчээ.

63.3/5Хят/

Ш-96

Б-24378-24380

Юань улсын судар / Эрхл. Г.Аким, М.Баярсайхан. -УБ.:Соёмбо, 2016.- ISBN 978-99973-78-90-3 (Боловсрол,Соёл,Шинжлэх Ухааны Яам, Монгол Судлалын Үндэсний Зөвлөл,Монгол Улсын Үндэсний Номын Сан)

“Юань улсын судар”-ын орчуулгын “Хураангуй зүйл”-ээс 69-р дэвтэр хүртэлх хэсгийг 6 ботиор эмхлэн хэвлүүлсэн. Үлдсэн 140 дэвтрийг хэвлүүлж,18 хүртэлх боть хэвлэгдэн гарсан. Энэхүү судар Дандаа чянсан хэмээх Дэмчигдоржийн орчуулгаар толилуулж байна. Чингис хаанаас эхлээд Хубилай хаан хүртэлх Монголын хаад, хатад, жанжны цадиг гээд бүх хүмүүсийн намтар түүх энэ сударт бий. Ер нь судар бичгүүдэд ихэвчлэн хаадын намтар түүх бичигддэгээс биш баатар, жанжны түүх орхигддог. Харин энэ сударт бүгдийг цогцоор бичсэн нь томоохон онцлог болсон хэмээн редакцийн зөвлөлөөс дүгнэжээ.

63.3(1)43

Ю-12

Б.7.Дэвт LXX-LXXIX. -584х.	/НУН-унш-3ш/	Т-18338-18373
Б.8.Дэвт LXXX-LXXXVIII. -568х.	/НУН-унш-3ш/	Т-18341-18343
Б.9.Дэвт LXXXIX-XCVIII. -600х	/НУН-унш-3ш/	Т-18344-18346
Б.10.Дэвт XCIX-CXIII. -607х.	/НУН-унш-3ш/	Т-18347-18349
Б.11.Дэвт CXIV-CXXVII. -594х.	/НУН-унш-3ш/	Т-18350-18352
Б.12.Дэвт CXXVIII-CXXXIX. -607х.	/НУН-унш-3ш/	Т-18353-18355
Б.13.Дэвт CXL-CLI. -593х.	/НУН-унш-3ш/	Т-18356-18358
Б.14.Дэвт CLII-CLXII. -643х.	/НУН-унш-3ш/	Т-18359-18361
Б.15.Дэвт CLXIII-CLXXII. -639х.	/НУН-унш-3ш/	Т-18362-18364
Б.16.Дэвт CLXXIII-CLXXXIII. -605х.	/НУН-унш-3ш/	Т-18365-18367
Б.17.Дэвт CLXXXIV-CXCV. -582х.	/НУН-унш-3ш/	Т-18368-18370
Б.18.Дэвт CXCVI-CCX. -640х.	/НУН-унш-3ш/	Т-18371-18373



Янь М. **Эргэлт** /Хятад хэлнээс орч. Б.Гэрлээ; Ред. Б.Ганчимэг. - УБ.:Монсудар, 2016. -106х. -ISBN 978-99973-1-367-6.

Сүүлийн арван жилд Хятад шиг хурдан хөгжсөн улс тун цөөн гэдэгтэй хүмүүс санал нийлэх биз. Гэвч энэ хөгжил өндөр үнээр олдож хувь хүн, нийгэмд ихээхэн хохирол учруулсныг Мо Янийн энэ романд өгүүлжээ. Хятадаас утга зохиолын салбарт Нобелийн шагнал хүртсэн анхны хүн болох Мо Яньэнэхүү намтарчилсан тууждаа, соёлын хувьсгалын хөлд хохирч хоцорсон хүүхэд ахуй наснаасаа эхлэн хожим алдартай зохиолч болох хүртэлх хувийн амьдралаа, Хятадын нийгмийн амьдралын өөрчлөлт, хувьсалтай зэрэгцүүлэн хүүрнэсэн байна.

63.3(5Хят)-8
Я-60

/НУН-унш-4,ГНОФ-3ш/

Б-24513-24515

ЭДИЙН ЗАСАГ


Будням С., М.Банзрагч М. **Эконометрик**: Гарын авлага /Ред. С.Будням. - Анхны хэвлэл. -УБ.:МУИС., 2016. -160х. -ISBN 978-9997-342-45-4.

Энэхүү сургалтын гарын авлагад эдийн засгийн процессын шинжилгээний арга хандлага, хос болон олон хэмжээст загварууд, нэгэн зэрэг тохиох тэгшитгэлүүдийн систем тэгшитгэлүүдээс гадна эконометрик загваруудын параметруудийн үнэлэл, тайлал, үнэлгээний аргуудыг авч үзсэн болно. Ялангуяа, хугацааны цуваан нэгэн зэрэг тохиох систем тэгшитгэлийн шинжилгээнд ихээхэн анхаарал хандуулав. Уг гарын авлага нь оюутнууд, аспирантууд, их дээд сургуулийн багш нар болон аналитик шинжилгээ хийдэг байгууллагуудын мэргэжилтэ-нүүдэд зориулав. Эдийн засгийн мэргэжлээр суралцаж буй оюутан бо-лон эконометрик сонирхогч багш, судлаач нарт зориулав. Гарын авлагад шугаман регрессийн (хос ба олон хувьсагчийн) загварын параметруудийн үнэлэлт байгуулах хамгийн бага квадратын тэдгээрийн өргөтгөлүүд, авторегрессийн процесс, шугаман загвараар прогиоз хийх, регрессийн тэгшитгэлийн системийн загвар, хугацааны стационар болон стационар биш цувааны загварын онцлог зэрэг асуудлыг авч үзэж, эдийн засгийн практик хэрэглээний жишээ бодлогуудыг бодож оруулсан.

65в6

Б-69

/ХШУИС-10ш/



Бэнс М. **Бохир мөнгө**: Австралийн ашигт малтмалын хөгжлийн бодит байдал /Орч. Б.Алимаа. -УБ.: Монсудар, 2013. -326х. -ISBN 978-99973-1-056-9.

Шунал, бохирдол, аллага...байгаль орчны бохирдлын талаар гомдол мэдүүлж зүрхлэх хэнийг ч болов өршөөлгүй нухчин дарсаар... Ховордож буй нөөц баялгийг газар шорооноос маш түргэн ухаж гаргаж, ингэснээр гол горхи бохирдож, хүүхдүүд хордож, байна. Энэ бол Австралийн ашигт малтмалын салбарын хөгжлийн бодит түүх. “Бохир мөнгө” бүтээлд Австрали улсын баялгийн түүх болоод давуу талаа ашиглаж хэрхэн энэ бүхнийг бий болгосон тухай өгүүлнэ.

65.304.11

Б-94

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24561-24563

Имай М. **Гэмба Кайзэн** /Орч. Б.Оюунчимэг; Хян. Б. Амарсайхан, Ц.Батбилэг.- УБ.:Мөнхийн үсэг, 2015. -208х. -ISBN978-99962-3-771-3.

Бизнесийн ертөнцөд цахиур хагалсан аль ч эрхмээс илүүтэйгээр Масааки Имай үзэл бодол, үг яриа болон үйл хэргээрээ дэлхий даяар кайзэний концепцыг манлайлан дэлгэрүүлж байгаа билээ. Чанарын хөдөлгөөнийг оройлогчдын нэгд тооцогддог Ноён Имай бол дэлхий даяар салбартай Кайзэн институтын дарга, олон улсын илтгэгч бөгөөд зөвлөх юм. Ноён Имайгийн анхны ном Кайзэн 14 хэлнээ орчуулагдан, 179000 хувь борлогдож чанар болон удирдлагын тухай “библи” гэгдэх болжээ. Гэмба Кайзэн бүтээлд өмнөх Кайзэнд орхигдсон хамгийн сүүлийн үеийн чанарыг сайжруулах арга, мөн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон үйлчилгээ үзүүлэхэд тэдгээр аргыг хэрхэн ашиглахыг зааж таны бизнест амин чухал ажиллагааг танилцуулсан ажээ.



65.290

И-50

/НУН-унш-3ш/

T-18325-18326



Моломжамц Д. **Нягтлан бодох бүртгэлийн онол** /Ред. Б. Хишигдэлгэр. -1 дэх хэвл. -УБ.:МУИС, 2017. -298х. -ISBN 978-99962-61-63-3.(МУИС Бизнесийн сургууль)

Монгол Улсад шинжлэх ухааны үндэслэлтэй нягтлан бодох бүртгэл үүсэж хөгжсөнөөс хойш 90 гаруй жил болж байна. Түүхэн энэ цаг хугацаанд манай улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд гарсан томоохон өөрчлөлт бүр нь бизнесийн хэл болсон нягтлан бодох бүртгэлийн хөгжилтэй салшгүй холбоотой байсан. Тиймээс зохиогч мянга мянган нягтлан бодогчид, энэхүү мэргэжлийг сонгон судалж буй оюутан сурагчид, магистрант докторантуудад зориулан энэхүү номонд нягтлан бодох бүртгэлийн үүсэл хөгжил болон нягтлан бодох бүртгэлийн данс, дансны давхар бичилт, нягтлан бодох бүртгэл хөтлөх үе шат, арга зүйг судалж мэдэхэд дөхөм байдлыг ихэд анхаарч өөр хооронд нь логик дараалалд оруулан энгийн бөгөөд ойлгоход хялбар, сонирхолтой, хүртээмжтэй, үр өгөөжтэй байх талаас нь бичжээ.

65.052

М-68

/НУН-унш-4,ГНОФ-3ш/

T-18329-18331

Оюунбилэг П. ба бус. **Бизнесийн мэдээллийн систем**: Онол ба хэрэглээ. Сурах бичиг /Н.Баттүшиг, Д.Онцгэрэл; Хян. О.Төлеу. -УБ.: Соёмбо, 2016. -330х. /CD-тэй/ -ISBN 978-99929-2-605-5.

Их дээд сургуулийн бизнесийн удирдлагын болон компьютерийн ухааны мэргэжлийн багш, оюутнууд, банк санхүү, бизнесийн байгууллагын менежерүүд, бизнес эрхлэгч хувь хүмүүст зориулагдсан энэ сурах бичигт өнөө үед чухлаар тавигдаж байгаа бизнес өгөгдлийг боловсруулах, шинжлэх, улмаар шийдвэр гаргахад ашиглах систем, програм хэрэгслийн талаар нилээд дэлгэрэнгүйгээр онолын үндэслэл болон практик хэрэглээ талаас нь авч үзжээ. Мөн PivotTable-ийн үндсэн боломж, Slicer, Timeline арга хэрэгсэл, PivotTable, PivotChart ашиглан Dashboard байгуулах арга зүй, Business intelligence/BI/ системийн онол практик, Tableau, Power BI, QlikView зэрэг системүүдийг тайлбарлажээ. Сурах бичгийн агуулгад хэрэглэгдэж буй файлуудыг CD болгон хавсаргажээ.



65.290-2я73

О-63

/НУН унш-4, ГНОФ-3, БС-10, ХШУИС-10ш/

T-18427-18429



Чимгээ Д., Эрдэнэчимэг Ж. **Бизнесийн мэдээллийн систем**: Сурах бичиг /Хян. Д.Хонгорзул, Б.Энхтуул. -УБ.: МУИС-ийн хэвлэх, 2016. -432х. -ISBN 978-99962-4-522-0.

Энэ сурах бичигт бизнесийн байгууллагын мэдээллийн систем, байгууллага мэдээллийн технологи ашиглан өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, мэдээлэл харилцаа холбооны технологийн үндсэн ойлголт, мэдээллийн ёс зүй ба аюулгүй байдал, электрон бизнес, өгөгдлийн сангийн удирдлага, өгөгдлийн агуулах, нийлүүлэлтийн сүлжээний удирдлага, хэрэглэгчийн харилцааны удирдлага, байгууллагын нөөц төлөвлөлтийн систем, ERP, SCM, CRM систем, мэдээллийн системийн хөгжүүлэлт гэсэн бүлгүүдийг багтаажээ. Мөн бүлэг бүрийн эцэст хэлэлцэх сэдэв, дасгал, тестийг оруулжээ.

65.290-2я73

Ч-62

/БС-10ш/

Эдийн засгийн ухаан 30 секундэд: Эдийн засгийн ухааны 50 сонгодог ойлголтыг хагас минутад багтаасан тайлбар /Эрхл. Доналд Маррон; Орч. Ж.Үнэнбат. -Анхны хэвлэл. -УБ.:Нэпко, 2016. -159х. -ISBN 978-99973-990-3-8.



Эдийн засгийн ухаан нь нийгмийн шинжлэх ухааны физик байхыг хүсдэг. Физикчид атомын дотоод элементээс авахуулаад тэнгэр эрхсийн биетүүд хүртэл байгалийн үндсэн хүчин зүйлсээр тодорхойлогддог болохыг судалдаг. Тэгвэл эдийн засагчид нийгмийн үндсэн хүчин зүйлсээр талхны үнээс авахуулаад АНУ ба Зимбаб улсуудын баялаг яагаад ялгаатай байдгийг судалдаг. Энэхүү номын үндсэн санаа нь хэдийгээр эдийн засагчид амжилтанд хүрч байгаа боловч эдийн засгийн ухаан хэзээ ч физик болохгүйд оршино. Сүүлийн хоёр зууны турш эдийн засагчид зах зээл хэрхэн ажилладаг хийгээд заримдаа бүтэлгүүддэг, хэрэглэгчид, ажиллагсад, пүүсүүд болон улстөрчид яаж шийдвэр гаргадаг, яагаад эдийн засаг өсдөг эсвэл уналтанд ордгийг тайлбарласан дараагийн хуудсуудад өгүүлэх олон онол бий.


65я2

Э-19

/НУН-унш-4,ГНОФ-3,ШУС-НУС-5ш/

Т-18461-18463

УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН



Батцэцэг Ч. Монгол-Хятадын харилцаа: шинэ боломж, сорил: Эмхэтгэл. -УБ.:Бит Пресс, 2016. -228х. -ISBN 978-99978-4-062-2 (Монгол Улс Шинжлэх Ухааны Академи Олон Улсын Харилцааны Хүрээлэн)

Өнөөдөр манай урд хөрш БНХАУ дэлхийн эдийн засгийг тэргүүлэх эгнээнд алхаж, цэрэг, улс төрийн нөлөө, байр суурь нь улам есен нэмэгдэж байна. Ялангуяа Хятад нь улс орнуудын эдийн засгийн хөгжлийг холбох бүтээн байгуулалтын "Торгоны зам", "Далайн торгоны зам", "Хятад, Монгол, Орос гурван улсын коридор" зэрэг томоохон төслүүдийг санаачлан эхлүүлж буй нь манай улсад нөлөөлөх асар том хүчин зүйл, хөгжлийн шинэ нехцөл, шинэ боломж, бас шинэ сорил юм. Иймд бидний өмнө хөршийнхөө гадаад бодлого, эдийн засгийн хөгжил дэвшил, түүх, соёлыг нь бүхий талаар сайтар таньж мэдэх, бүрэн дүүрэн судлах шаардлага тулгарч байна. Энэ судалгаа нь ялангуяа Монгол, Хятад хоер улсын хооронд тогтоосон иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг цаашид хэрхэн харилцан ашигтай хөгжүүлэх, манай улс өөрийн аюулгүй байдал, гадаад орчин, эрх ашгаа хамгаалах хийгээд эдийн засгийн хөгжлийгурагшлуулах боломж, эерэг, сөрөг талыг урьдчилан таамаглахад чухал ач холбогдолтой.

66.4

Б-33

Б-24471-24473

Бор Ж., Уламбаяр Д. Монголын дипломатын нэвтэрхий толь бичиг: Гурамсан боть /Б.Батцэвээн, Д.Далайжаргал; Ред. Д.Баатар. -2 дахь хэвл. -УБ.: Адмон, 2016. -ISBN: 978-99973-0-186-4.

Энэхүү нэвтэрхий толь бичигт Монголын дипломатын 3213 жилийн түүхэнд дэвсгэрлүүлэн олон улсын харилцаа, дипломатын ажиллагаа, дипломат ёслол ба журамлал, олон улсын эрх зүй, геополитик, дэлхийн түүхийг өөрчлөн эргүүлсэн түүхийн гол гол үйл явдлууд, НҮБ, түүний мэргэшсэн байгууллагууд, олон улсын байгууллагын түүх болон танилцуулга, олон



улсын эдийн засгийн харилцаа, олон улсын яриа хэлэлцээ, гэрээ хэлэлцээр, конвенциуд, дэлхийн дипломатын түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн төрийн зүтгэлтэнүүд, дипломатын намтар, эртний ба өнөөгийн Монгол улсын гадаад бодлого, Монголын дипломатын түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн гадны дипломатууд, тэдний намтар, мөн улс төрийн шинжлэх ухааны нэр томьёоны тайлбарыг багтаасан ба толь бичгийг А-И, К-Р, С-Я гэж 3 боть болгон хэвлүүлжээ.

66.4я2
Б-60

Б.1: А-И. -719х. Т-18411
Б.2: К-Р. -735х. Т-18412
Б.1: С-Я. -720х. Т-18413



Мягмаржав Б. **Олон улсын эдийн засгийн харилцаанд “Алтан ордон улс”-ын оруулсан хувь нэмэр.** Б.13(4) /Ред. О.Сүхбаатар. -УБ.:Соёмбо, 2016. -378х. - ISBN 978-99962-75-16-6. (Дэлхий-Олон улс-Монгол улс - цуврал, Монголын их дээд сургуулийн консорциум, ХААИС, Чингис хааны нэрэмжит Их Засаг олон улсын их сургууль)

Уг бүтээл нь 3 хэсэг, 13 бүлэг, 73 дэд бүлэгтэй томоохон бүтээл бөгөөд Еврази, Төв, Дундад, Өмнөд Ази, Арабын хойг, Умард Африкийг хамруулан Их Монгол Улсыг орчин үеийн олон улсын эдийн засгийн харилцаа, олон улсын маркетинг, дэлхийн эдийн засгийн үүднээс судалсан нь түүхэн үйл явдлыг орчин үетэй холбосон судалгааны шинэ чиглэл хэмээн эрдэмтэн судлаачид үзэж байна. Бүтээлд Монголын Эзэнт Гүрэн дэлхийн аж ахуй, олон улсын эдийн засагт томоохон байр суурь эзлэхүйц ач холбогдолтойг харуулсан цогц судалгааны үр дүнг тусгасан нь орчин үеийн олон улсын эдийн засгийн харилцаа болон дэлхийн эдийн засагт чухал ач холбогдолтой ажил болжээ. Нөгөө талаар дэлхийн олон оронд амьдарч буй монгол туургатан орнуудын их, дээд сургуулийн багш оюутнуудад Монголын Эзэнт Гүрний энэхүү бодит түүхэн туршлага нь онол практикийн чухал ач холбогдолтой болохыг онцлож байна.

66.4
М-98

Т-18316-18318

Надилов Ш.Г **Ю.Цэдэнбал 1984** /Ред. Д.Ёндон, Б.Баасансүрэн; Орч. Ю.Кручин, Б.Баасансүрэн. -УБ.:Интерпресс, 2016. -212х. -ISBN 978-99962-52-69-3.

1984 оны наймдугаар сард Монголын дээд удирдагч гэнэт өөрчлөгдсөн хэрэг явдал олон хүнд өнөө болтол оньсого хэвээр үлджээ. Эрх баригчдын албан ёсны шийдвэрээр бол, Ю.Цэдэнбалыг төрийн бүх өндөр албан тушаалаас нь "эрүүл мэндийн байдлыг нь харгалзан, өөрийнх нь зөвшөөрснөөр чөлөөлөв" гэсэн бол үүний зэрэгцээ монголын олон нийтийн тодорхой хэсгийн хүрээнд тэрбээр эрүүл саруул байсан бөгөөд, эрүүл мэнд нь тухайн үед албан тушаалаас чөлөөлөх зайлшгүй учир шалтгаан болох учиргүй байсан юм гэдэг итгэл үнэмшил өнөө болтол тун тууштай яригдсаар байгаа билээ. Үнэн хэрэгтээ юу болов? Ю.Цэдэнбал эрхэлж байсан бүх дээд албан тушаалаасаа биеийн байдлаасаа болж, сайн дураараа чөлөөлөгдөв уу? Аль эсвэл хүсэл зоригийг нь сөрж, албан тушаалаас нь зайлуулав уу? Хэрэв энэ сүүлчийнх нь хувилбар лавтай бол тийм боломж хэрхэн, яаж гаргав? Эх сурвалжуудад үндэслэгдсэн материалууд л тухайн үйл явдлыг зөв тайлж, таниулахад нэлээд чухал төдийгүй дээр дурдагдсан асуултуудад буурьтай хариулт өгөх боломжтой юм.

66.3(1)8

Н-16

/НУН-унш-10, ШУС-НУС-5ш/

Б-24449-24453





Улс төр судлал 30 секундэд: Улс төрийн сэтгэлгээний 50 сонгодог ойлголтыг хагас минутанд багтаасан тайлбар /Эрхл. Л.Тэйлор; Орч. Б.Батчулуун, Б.Батбуян. -Анхны хэвлэл. -УБ.:Нэпко, 2016. -160х. - ISBN 978-99973-990-5-2.

Улс төрийн шинжлэх ухааныг нэг талаас үзвэл, нарийн ширийн элдэв нэр томьёо, онолыг судлах ёстой мэт боловч нөгөө талаас, ерөнхийдөө улс төр судлалд багтдаг дараах багц асуудлыг авч үзэх ёстой болдог: дайн ба энх, эрүүгийн хуулийн шударга байдал, татвар, аюулгүй байдлын журамлалт, иргэний эрх ба эрх чөлөө, худалдаа арилжаа, үр хөндөлт, гэр бүл, шинжлэх ухааны судалгаа шинжилгээ явуулах дүрэм журам (энд цөөн хэдэн асуудлыг тоочлоо) зэрэг. Эдгээр асуудалд та бидний амьдралыг тодорхойлдог гол утга нь байгаа юм. Асуудлыг өөр өнцгөөс харъя: хэрэв Өмнөд Солонгосын нэг иргэн Хойд Солонгостөрсөн бол түүний өдөртутмын амьдрал, материаллаг нөхцөл, хүний эрх, эрх чөлөө гээд бүх зүйл шал өөр байх байлаа. Товчхондоо: ийм байгаа нь улс төрөөс хамааралтай гэсэн үг. Улс төрийн нарийн, ээдрээт байдал, түүнтэй холбоотой нэр томьёог энгийн ойлгомжтой илэрхийлэх нь энэ номын зорилго болно.

66.0я2

У-31

/НУН-унш-4,ГНОФ-3,ШУС-НУС-5ш/

T-18458-18460

ХУУЛИЙН ШИНЖЛЭХ УХААН

Баярсайхан Д. **Эрх зүйн онол.** -4 дэх хэвл. -УБ.:Соёмбо, 2016. -330х. - ISBN 978-99929-69-98-9.

Энэ удаа хэвлэн гаргаж буй эрх зүйн онол нь хууль зүйн шинжлэх ухааны сүүлийн үеийн ололт, үр дүнг бүтээлчээр тусгаж, англи хэл дээр хэвлэгдсэн эрх зүйн онолын эх сурвалж, ном, сурах бичиг, онол, арга зүйн сэтгүүлүүдийг аль болох өргөнөөр ашиглахыг эрмэлзсэнээрээ өмнөх бүтээлээс ялгаатай. Уг номонд эрх зүйн философийн категори, ухагдахуун зохих хэмжээнд тусгалаа олсны дээр харьцуулсан эрх зүй судлалын онолын тулгамдсан асуудлууд ч хөндөгджээ.

67.0

Б-38

/НУН-унш-3,ХЗС-10ш/

Б-24443-24445



Монгол Улсаас бусад улстай байгуулсан иргэн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт этгээдийг шилжүүлэх, ялтан шилжүүлэх тухай гэрээний эмхэтгэл /Эмхт. М.Мөнх-Алдар; Хян. Э.Зоригт. -Анхны хэвлэл. -УБ.:Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэр,-2016. -554х.-ISBN 978-99973-983-2-1.

(Монгол Улсын Засгийн Газар Хууль Зүйн Яам)

Монгол Улсын гадаад харилцаа өргөжин тэлэхийн хэрээр эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай асуудлын ач холбогдол улам бүр нэмэгдэж байна. Монгол Улс нь 2016 оны байдлаар нийт 20 улстай 28 төрлийн эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг байгуулсан байна. Тэдгээрээс иргэний хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг 17 улстай, эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг 17 улстай, гэмт этгээдийг шилжүүлэх тухай гэрээг 17 улстай, ялтан шилжүүлэх тухай гэрээг 9 улстай тус тус байгуулаад байна.


67.412.1

М-69

/ХЗС-2ш/

Нарангэрэл С. **Монгол-Англи хууль зүйн толь бичиг** /Бэлт. Д.Оюун. -УБ.:Адмон, 2016. -259х. -ISBN 978-99973-0-994-5.

Энэхүү толь бичигт монголын хууль зүйн шинжлэх ухаан, шүүхийн практикийн суурь 12000 гаруй нэр томъёо ба хэллэгийг англи хэлнээ дүйцүүлсэн байна. Эл бүтээл нь монголын нийтийн ба хувийн эрх зүй, олон улсын эрх зүй, түүнчлэн хууль зүйн онолын ба хэрэглээний (хавсрага) судлагдахууны (төр, эрх зүйн онол, түүх, криминологи,криминалистик, шүүх эмнэлэг зэрэг) нэр томъёо ба хэллэгийг багтаасан, монгол- англи хууль зүйн мэргэжлийн анхны томоохон суурь толь бичиг юм.



67+81.2Анг

Н-29

/НУН-унш-3,ХЗС-10,Лав-1ш/

Б-24438-24439



Нарангэрэл С. **Хуулийн амин сүнсний эрэлхийлэл**: Чингис хааны гэрээс. -УБ.:Жиком, 2016. -124х. -ISBN 978-99929-25-87-4.

Зохиогч Содовсүрэнгийн Нарангэрэл Монгол Улсын ШУА-ын жинхэнэ гишүүн буюу академич, Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, Япон улсын Нагояагийн Их сургуулийн хүндэт доктор. Академич С. Нарангэрэл “ Монголчуудын зан суртахууны гарваль,2010”,”Чингис хааны сүр хүч,2013”, “Чингис хааны ёс суртахуун-эрхзүйн шаштир,2014”,”Ёс суртахууны монгол цагаан толгой,2015” зэрэг ёс суртахуун ба эрхзүйн харилцан хамаарлын тухай шинжлэх ухааны болон хялбаршуулсан бүтээл туурвижээ.Энэ удаа уншигч тандаа “Хуулийн амин сүнсний эрэлхийлэл”: Чингис хааны гэрээс хэмээх бүтээлийг толилуулж байна.

67.3

Н-29

/НУН-унш-3,ХЗС-10ш/

Б-24440-24442

“Хууль зүйн нэр томъёоны судалгаа,хэрэглээ” сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл /Эмхт. А.Түвшинтулга. –УБ.:Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэр, 2016. -247х. –ISBN 978-99973-861-6-8. (Монгол Улсын Их Хурлын Тамгын Газар, Хууль Зүйн Яам, Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн,Монголын Хуульчдын Холбоо, ШУА-ийн Философийн Хүрээлэн, ШУА-ийн хэл зохиолын хүрээлэн)




Хууль бол нийгэмд үнэн, шударга ёс, жудаг, илтгэлийг тогтоогч сонгомол хэрэглүүр мөн. Хуулийн агуулга нэр томъёоноос бүрддэг. Хэрэв хоёрдмол утгатай, ойлгомжгүй, гуйвуулахад хялбархан байвал хууль завхарахад хүрдэг. Хууль завхарвал улс гүрэн доройтож, ард түмэн хөл толгойгоо алддаг. Иймд хууль зүйн нэр томъёо маш ончтой, тогтвортой байх ёстой. Тус хамтарсан эрдэм шинжилгээний хуралдааны явцад Монгол Улсад хууль зүйн нэр томъёоны сан хөмрөг эрдэмтэд судлаачдын олон жилийн цөхрөлтгүй хөдөлмөрийн үр дүнд бүрдсэнийг онцлон тэмдэглэж, түүнд суурилан цаашид хөгжүүлэн баяжуулах зайлшгүй шаардлага үүссэнийг хөндөж тавьжээ.Хууль зүйн нэр томъёо судлалын хөгжилд хэл шинжлэлийн ухааны ололтыг бүтээлчээр ашиглахын чухлыг ч онцолсон.

67+81

Х-75

/ХЗС-5ш/

ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Соёмбо нэвтэрхий толь: Монгол цэргийн түүх /Ред. Э.Жаргалмаа. - УБ.:Соёмбо, 2015. -512х. -ISBN 978-99973-77-42-5.

Монголд цэрэг арми бусад улс орныхтой адил анх бие даасан овог аймгууд үүсэн бий болж, тэдгээрийн тэргүүлэгчид гадны халдлагаас хамгаалах, харь овгийг байлдан дайлх зорилгоор хатгалдан тулалдах авьяас чадвартай хүмүүсийг сонгон тусгай баг бүрдүүлэх болсон үеэс үүсэн буй болжээ. Энэхүү нэвтэрхий тольд Монгол цэргийн түүхийг Хүннү, Сяньбигаас эхлээд Их Монгол улс, Чингис хаан, Юань улсыг дамнуулан Тусгаар тогтносон Монгол улс, Дэлхийн II дайны үе, Ардчилсан нийгмийн үеийн Монгол улсын зэвсэгт хүчин хүртэлх цаг хугацааг хамруулан тухайн үеийн төр, цэргийн зохион байгуулалт, зэр зэвсэг, явуулсан дайн байлдаан, тэмцэл тулаан, цэргийн урлагийн уламжлал, хөгжил болон домогт жанжинууд, баатарлаг ялалтуудын талаар маш дэлгэрэнгүй авч үзжээ.

68.49(1)я2

С-52

/НУН-унш-3,ГНОФ-3,Лав-1ш/

Т-18379-18381

БИЕИЙН ТАМИР,СПОРТ

Чимэдцэрэн Д. Аялахын тулд баян байх хэрэгтэй юу? Өдрийн 30 000 төгрөгөөр 7 сар, 10 улсаар аялсан тэмдэглэл /Ред. М.Амарбат. -УБ.: Мөнхийн үсэг, 2016. -320х. -ISBN978-99962-64-51-1.


Залуу аялагч Д.Чимэдцэрэнгийн БНХАУ, Вьетнам, Камбожи, Тайланд, Лаос, Мьянмар, Малайз, Сингапур, Индонез, Филиппин зэрэг Азийн орноор 7 сарын хугацаанд өдрийн 30 000 төгрөгөөр хэрхэн аялсан тухай өгүүлэх энэ номыг улс орноор аялах сонирхолтой, чин сэтгэлийн хүсэл тэмүүлэлтэй хүн бүхэнд толилуулж байна. Энэ номонд аялах хүсэл сонирхолтой байж, тэр хүсэл мөрөөдлөө бодит болгох, хэрхэн аялах зардлаа бүрдүүлэх, бэлтгэл ажил, тухайн улс орноор аялсан аялалын чиглэл, улс орны түүх, өдөрт хэдэн төгрөг зарцуулсан, төсөөллөөс тэс өөр зүйлүүд, миний нүдээр, байрны асуудал, заавал үзэх газруудын тухай дэлгэрэнгүйгээр өгүүлжээ.

75.81

Ч-62



Т-18443-18445



Шатрын нэвтэрхий толь /Эмхт. Л.Үржиндорж; Ред. Б.Нямдаваа,Ш.Батбилэг. -УБ.:Соёмбо, 2016. -366х. -ISBN 978-99962-75-79-1.

Шатар бол хүн төрөлхтөний оюун санааны гайхамшигт бүтээлүүдийн нэг мөн. Шатар хүнд хүсэл эрмэлзлэл, зорилго, хатуужил, тэсвэр тэвчээр, тооцоолох хурд, нөхцөл байдалд түргэн бөгөөд зөв шийдвэр гаргах зэрэг нийгэмд чухал шаардлагатай чанарыг төлөвшүүлдэг.Шатар тоглох нь хүүхдийн дүрслэн бодох болон логик сэтгэлгээг хөгжүүлж, зорилго тэмүүлэлтэй, хэрсүү,буйр суурьтай болгон хүмүүжүүлдэг. Уг нэвтэрхий толь нь шатар анх үүссэн үеэс эхлэн түүхийн урт хугацаанд тодрон гарсан дэлхийн аваргууд, нэр цуут шатарчдын товч намтар, шатрын өргийн эхэн, дунд, төгсгөл үед тэдний тоглодог арга техник, тоглолтын ур чадвар болон уран комбинацитай шатарчидтай танилцах боломжийг олгоно. Мөн монголын шатрын хөгжлийн түүхэн замнал, монголын шатрын бодлого зохиомж, бодлого бодолтын

хөгжил, дэлхийд нэрээ дуурсган монголоос төрөн гарсан анхны болоод бусад олон улсын их мастеруудын товч намтар, тэдний бүтээл, тоглосон өргүүдээс оруулсан болно.

75.581я2

Ш-34

/БУН-унш-2,Лав-1ш/

T-18374-18375

ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

Балдорж шагнал: Сэтгүүл зүйн шилдэг бүтээлүүд /Ред. С.Батбаатар, Д.Заяабат. -УБ.:Мөнхийн үсэг. -ISBN 978-99973-2-154-1.

Сэтгүүлчдийн бичсэн нийтлэл, тэмдэглэл, сурвалжлага,ярилцлага, хөрөг, эсээ, найруулал гээд сэтгүүл зүйн бүхий л төрлөөр бичигдэж, нийгэм, эдийн засаг, улс төр, хууль ёс, байгаль орчин, урлаг утга зохиол, шинжлэх ухаан, спорт гэх зэрэг маш олон салбарын өргөн дэлгэр сэдвийг хөндсөн монголын сэтгүүл зүйн дээжис бүтээлийг уншигч танд барьж байна.



76.01 Шилдэг бүтээлүүд: /2009-2012/ 2013. -508х. /НУН-3ш/

Б-24432-24434

Б-21 Шилдэг бүтээлүүд:/2013-2015/ 2016. -526х. /НУН-3ш/

Б-24435-24437



Болд-Эрдэнэ Б. Реклам, харилцаа, сэтгэлзүй, билэгдэл: Сурах бичиг /Ред. Ц.Хүрэл-Очир. -УБ.:Жиком пресс, 2016. -238х. -ISBN 99929-845-2-х.

Доктор Б.Болд-Эрдэнийн бичсэн энэ бүтээл нь реклам, түүний дотор ОНМХ-ийн зар сурталчилгааны талаарх анхны сурах бичиг бөгөөд Рекламын харилцааны хэрэглэгчид, Рекламын харилцааны мэдээлэгч, Рекламын суваг, харилцааны сэдэв агуулга, тэмдэгтийн тогтолцоо гэсэн үндсэн бүлэгт багтаан рекламын харилцааны онол, практикийн асуудлуудыг тодорхой жишээ баримтад тулгуурлан тусгажээ. Зохиогч уг бүтээлдээ реклам сурталчилгаанд өргөн хэрэглэдэг Юнгийн онол, Маслоугийн онол, Селф- Концепцийн онол, Курт Левиний сэтгэл зүйн орчны онол, Осгуудын онол, Фестингерийн онол, Феминизмийн онол, Фрейд, Неофрейдийн онол, Психоанализийн онол, Хорнейн онол, Эриксоны онол, Ризманы онол, Ангиллын онол, Зан чанарын онол, Санаа зорилгын онол, Шинж тэмдэгийн онол, Дахин тодотгохын онол, Үнэлэлт дүгнэлтийн онол, Үйл байдлын үнэлэлтийн онол, Оюун дүгнэлтийн учир шалтгааны онол, Харьцаа дүгнэлтийн онол, Адилсалын онол, Бэлгийн хөгжлийн онол, Харилцааны үйл явцын онол, Зохион байгуулалтын онол, Эерэг тааламжийн онолуудыг тайлбарласан байна.

76.006.5я73

Б-54

/НУН-унш-4,ГНОФ-3,ШУС-НУС-10ш/

T-18319-18321

НОМЫН САН СУДЛАЛ.

Бурмаа Х. Ном, Номын сангийн ертөнцөөр /Ред. Ч.Гульнар. -УБ.: Сэлнэгэпресс, 2016. -368х. -ISBN-978-99973-3-899-0.

Номын сан болон номын ертөнцөөр аялуулах энэ номонд дэлхийн анхны номууд, МЭӨ үеийн ба дэлхийн тэргүүлэх номын сангууд, дэлхийн алдартай их сургуулиудын номын сан, Монгол улсын номын сангуудын товч түүх, Олон улсын номын сангийн холбоо IFLA, Номын олон улсын дугаар ISBN, номын сангийн олон улсын ангилал DDC, номын тэмдэг Ex-Libris-ийн тухай, дэлхийн номын сангийн гайхамшигтай



барилга байгууламж, дэлхийн алдартай номын дэлгүүрүүд, номонд зориулсан хөшөө дурсгал, номын музей, номын санг элдэв халдлагаас сэргийлж байсан зарим арга, номын сан халдлагад өртөж байсан тохиолдлууд, эртний гүн ухаантнуудын онч мэргэн үгс, “Британника” болон “Нэвтэрхий толь”-ийн тухай өгүүлжээ.

78

Б-75

Б-24576

ХЭЛ ШИНЖЛЭЛ



Амаржаргал Б. **Монгол – Япон толь бичиг техникийн** / Бэлт. Д.Ганчимэг. -УБ.:Адмон, 2015. -638х. -ISBN 978-99973-0-751-4.

Энэхүү толь бичигт техник, технологи, хими, физик, анагаах ухаан, спортын зэрэг 22000 үг хэллэг оржээ. Үгийн хуваарилалтыг оновчтой хийж үсэг дараалалаар байрлуулсан ба номын төгсгөлд хавсралтаар дэлхийн улс, газрын нэрийг цагаан толгойн үсгийн дараалалаар оруулсан ба Япон улсын муж, газрын нэрсийг ч мөн адил оруулж өгсөн

байна.

81.2М-4

А-51

/ШУС-БУС-3ш/

Т-18401-18402

Мишиг Л. **Монгол, манж хэл, бичиг судлалын өгүүллүүд** /Эмхт. Т.Отгонтуул, Э.Пүрэвжав; Хян. М.Баярсайхан. -УБ.: Гичнэнэ мандал, 2016. -218х. /Манж бичиг судлал: Цуврал. 2016. №1 /-ISBN99973-86-97-7.


“Манж бичиг судлал”цувралын энэхүү анхны дугаарт Монгол хэл шинжлэлийн ахмад эрдэмтэн, МУИС-ийн хүндэт профессор, доцент, манжич Л.Мишиг багшийн бүтээлийн жагсаалт, 1955-1995 оны үед хэл шинжлэл, монгол хэл, хамниган аялгуу, монгол бичиг, шинэ үсэг, үгний боловсрол, манж хэл судлалын талаарх эрдэм шинжилгээний өгүүлэл, ном товхимол, хэлсэн үг, товч намтар зэргийг багтаажээ.

81.2

М-65

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Т-18295-18297



Монгол бичиг номын өв /Б.Түвшинтөгс, Г.Баттогтох ба бус. -УБ.: Адмон, 2016. -389х. -ISBN-978-99973-0-999-0.

Энэ бүтээлд монголчууд бидний эртнээс хэрэглэж ирсэн монгол бичиг, дөрвөлжин бичиг, тод бичиг, али гали үсэг, соёмбо бичиг, хэвтээ дөрвөлжин бичиг, вагиндрагийн бичиг, латин бичиг, кирил бичиг үсгийн ангилал, үечлэлийн талаар тодорхой өгүүлэхийн зэрэгцээ тэдгээрийн дурсгал, түүний онцлог зэргийг олон арван өнгөт зураг, түүхийн дурсгалуудтай холбон тайлбарлажээ. Мөн монгол хэлээр ханз, араб, манж, төвд зэрэг харь үсгээр тэмдэглэсэн дурсгалуудыг тусад нь тоймлон танилцуулжээ.

81.2М

М-69

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Т-18507-18509

Монгол хэлний зурагт тайлбар толь: Англи нэршилтэй /Ред. Д.Хүрэлхүү; Зөвл. Баабар, Б. Түвшинтөгс, Б.Цэнддоо; Төслийн удирдагч. Б.Болдбаатар. -Анхны хэвл. -УБ.:Нэпко, 2015. -984х. - ISBN 978-99973-66-45-0. (Encyclopedia Britannica,Inc. QA INTERNATIONAL)



Дэлхийд нэртэй *Britannica* толь бичгийг эрхлэн гаргагч Encyclopaedia Britannica, Inc. компанийн захиалгаар QA INTERNATIONAL компанийн бүтээсэн *Visual Dictionary with Definitions* бөгөөд энэхүү номонд 6,000 гаруй өнгөт зураг дээр 20,000 гаруй үгийг монгол болон англиар хадмалдан бичиж, доор нь монгол тайлбарыг нь хавсаргасан болно. Ийнхүү толь ашиглагч тухайн зүйлийнхээ зураг дүрсийг үзэн таниж монгол, англиар нэршлийг нь тогтоохын зэрэгцээ тайлбарыг нь уншиж утга учрыг нь улам тодруулах ач холбогдолтой юм. Тиймээс энэхүү толийг нэршлийн, улмаар нэвтэрхий толийн чанартай гэж үзэж болох билээ.

81.2М-4

М-69

/БУН-унш-6,Лав-1ш/

Т-18292-

18294



Саруул-эрдэнэ М. **Зугаатай хэл шинжлэл** /Ред. Ц.Наранцэцэг. -УБ.: Мөнхийн үсэг, 2013. -202х. -ISBN 978-99973-2-234-7.

Зохиогч 2006 онд бичсэн “Сонирхолтой хэл шинжлэл” номын үргэлжлэл болгон “Зугаатай хэл шинжлэл” номоо толилуулж байна. Хэл шинжлэлийн онол, ухагдахууныг энгийн зугаатай аргаар тайлбарласан энэ номны “Хэл шинжлэлийг онигоогоор” бүлэгт бичил хошин яриа буюу онигоонуудын цаад хэл шинжлэлийн утга учрыг тайлбарлаж, “Зугаатай хэл шинжлэл” бүлэгт “Шүүх буюу криминалистикийн хэл шинжлэл”, “Хүүхдийн хэл яриаг судлах” хэмээх манайд арай хөгжиж амжаагүй салбар ухагдахуун, “Хэлний шинжлэл судалж хэл бичгээ хөгжүүлэе” бүлэгт практик санал, “Хэл гэж сонирхолтой ертөнцөд” хэмээх бүлэгт хэл шинжлэлийн элдэв сонин баримт, үгийн гарал үүслийн талаарх өгүүлүүд оржээ.

81.2-2

С-36

/НУН унш-3ш/

Б-24539-24540

Саруул-эрдэнэ М. **Сонирхолтой хэл шинжлэл** /Ред. Ц.Наранцэцэг. -2 дахь хэвл. -УБ.: Мөнхийн үсэг, 2015. -192х. -ISBN 978-99973-2-819-1.



Зохиогч хэлний онолын талаар өгүүлэхдээ зүгээр л хоёр найз суугаад хууч хөөрч байгаа мэт маш энгийнээр, эсвэл болсон явдал, онигоо ярьж буй мэтээр саналаа чөлөөтэй илэрхийлжээ. Энэ нь хэл шинжлэлийг судлаач нарт ойлгоход маш хялбар дөхөм болжээ. Хэл шинжлэлийг монгол хэлний тухайд ерөнхий, үг хийгээд үгийн сан, өгүүлбэр зүй ба үг зүй, авиа ба авиазүй, хэл шинжлэл бусад шинжлэх ухаантай холбоотой болох нь, зөв бичих дүрэм гэсэн 6 бүлэгт хуваан авч үзжээ.

81.2-2

С-36

/НУН унш-3ш/

Б-24537-24538



Түмэнбаяр Х. **Сайн галавын мянган бурханы нэр**: Бурхадых алдар нэрийн үүднээс танин барих, галиглах мэдэгдэхүүн Цуврал-1/Ред. Н.Батжаргал, Д.Мөнх-Отгон, Т.Баярлах, Б.Отгонтуяа, П.Анхмаа. –УБ.:Ном Бест, 2016. -536х. -ISBN 999625280-9.

Энэхүү ном нь бурхадых алдар нэрийг таньж мэдэх илүүтэйгээр судлахад тань туслах болно. Мөн шашин судлалын чиглэлээр суралцаж буй оюутан, магистрант, докторантуудад чухал ач

холбогдолтой, судалгааны ажилд нь дэм туслалцаа үзүүлэх болно.

81.1

Т-78

Б-24401-24403

Цогзолмаа Г. **Монгол Хятад хэлний цагийн айг харьцуулсан судалгаа**: Нэг сэдэвт бүтээл. -УБ.:Соёмбо, 2016. -221х. -ISBN 978-99962-75-21-0.



Алтай язгуурын монгол хэл, Хятад, төвд, тай язгуурын хятад хэлний цагийн айн онцлог шинж, харилцан хамааралтай байж болох талаар хийсэн энэхүү өвөрмөц судалгаа нь хэл шинжээчид, хятад хэл сонирхон суралцагч, судлаачдад, онол практикийн ач холбогдлоо өгөх нь дамжиггүй. Судлаач гарал үүслээрээ болон хэв шинжээрээ ялгаатай хоёр хэлний цагийн айн утга илэрхийлэх зүй тогтлыг онолыг үүднээс судалж, монгол хэлний цагийн айн хийсвэр шинж, хятад хэлэнд цагийг илэрхийлэх бодит онцлогийг нарийвчлан тайлбарлаж, өөрөөр хэлбэл дэлхийн хэлтнүүдийн нийтлэг шинж нь үйл үг нь цагаар хувирч байдаг бол тусгайлаг хэлэнд үйл үг нь задлаг хэлбэрт шүтсэн байдлаар илэрхийлдэг талаар дэлгэрэнгүй өгүүлжээ. Мөн монгол хэлний цагийг хэлзүйн аргаар илэрхийлдэг бол хятад хэлний цаг нь учирзүйн цагийг заах нэр үг, дайвар үг, туслах үгээр илэрдгээрээ өвөрмөц болохыг гаргажээ.

81.2М-3

Ц-75

T-18398-18400



Шинэбаяр О., Бат-эрдэнэ С. **Нэр томьёо судлал**: Улсын нэр томьёоны гишүүн Бямбын Ринчен-1,2 /Ред. Л.Болд. -УБ.: Соёмбо принтинг, 2015. - ISBN 978-99973-78-77-4.

Б.Ринчен 1937 он хүртэл улсын нэр томьёоны комиссын ажлын ачааг үүрч явсан цөөн хэдэн ахмадуудын нэг бөгөөд монгол хэлний шинэ нэр томьёоны анхны хэдэн дэвтэр толь бичгийг латин, орос, монгол хэлээр, үгийн хэлхээний хамтаар боловсруулан нийтлүүлэх ажлыг гардан хийж байсан гавьяатан юм. Суут эрдэмтний нэр томьёо судлалын талаарх “Улсын нэр томьёоны гишүүн Б.Ринчен” хэмээх энэхүү бүтээлийн 1-р ботид академич Б.Ринчен Улсын нэр томьёоны комисст ажилтнаар орж эхэлсэн, үргэлжлүүлсэн түүхэн цаг үе, амаргүй ажил үүргийг гүйцэтгэж ирсэн талаарх өгүүлэл, нэр томьёо судлалын хүрээнд бичсэн судалгааны болоод хэрэглээний олон өгүүлэл, нийтлэлүүд., 2-р ботид 1932-1937 онуудад хэвлэгдсэн “Нэр томьёоны бичиг”-ийн 5 дэвтэрийн бүрэн эх, мөн нэр томьёо үг хэллэгийн талаар бичсэн 10 гаруй өгүүлүүд тус тус оржээ.

81.2М-4

Б.1. -192х. T-18417-18418

III-66

/НУН унш-3ш/

Б.2. -432х.

T-18419-18420

АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ

Дулам С., Нандинбилиг Г. **Монгол аман зохиолын онол-1**: Аман яруу найраг /Ред. Д.Бум-очир. -2 дахь хэвл. -УБ.: МУИС пресс, 2016. -406х.

Нэмэлт засвар хийж, 2 дахь удаагаа толилуулж буй энэ номонд аман зохиол судлалын асуудлууд, ангилал, Монгол аман зохиолыг Орос, Монгол, Өрнө ба Дорно дахинд судалсан байдал, түүний төрөл зүйл, ангилал, өвөрмөц шинж, аман яруу найраг, аялгуут ба аялгуут бус аман яруу найраг, дом шившлэг, бэлгэ дэмбэрлийн үг, ертөнцийн гурав, зүйр цэцэн үг, оньсого, ерөөл, магтаал, баатарлаг туульс, ардын дууны тухай өгүүлжээ.


82/1/

Д-64

/НУН унш-4, ГНОФ-3ш/

T-18449-18451





Монгол сонгодог туульс /Эмхт. Т.Баясгалан; Ред. Г.Энхбат, Ц.Жаргалсайхан; Бэлт. Б.Катуу. -УБ.:Соёмбо, 2016. -506х. -ISBN 978-99962-52-68-6 (Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны харьяа Соёлын Өвийн Төв)

Хэдэн зуугаас хэдэн түмэн мөр шүлгээс бүрдэл болох аман зохиолын хамгийн том хэмжээний энэ туурвил нь эртний домог үлгэрийн сэтгэлгээнээс өнөө үеийг хүртэлх шүтлэгийн болон уран сайхны сэтгэхүйн олон үе давхаргыг хадгалсан байхын хажуугаар үндэсний аман зохиолын олон төрөл зүйл, бүтвэр хэсгүүдийг ч өөртөө шингээсэн байдгаараа тун онцлогтой.

82.3(1)

М-69

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24454

УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ

Батжаргал Д., Амарзаяа Э. **Хүүхдийн уран зохиолын тайлбар толь** /Хян. Д.Галбаатар, Д.Оюунбадрах. -УБ.: Бэмби сан, 2016. -500х. -ISBN 978-99978-0-088-6.


Энэхүү тайлбар толь бичигт нэр томъёонуудыг зөвхөн судлаач бус энгийн уншигч ч ойлгохуйцаар аль болох дэлгэрэнгүйгээр тайлбарлаж, жишээ баримтаар баяжуулан оруулжээ. Уг бүтээл нь хүүхдийн уран зохиолын онол, арга зүйг судлаач оюутан, сурагчид нарт зориулагдсан бөгөөд энэ номонд хүүхдийн уран зохиолын онол, түүх, шүүмж судалгааны нэр томъёо, ойлголт, тайлбарууд, Монголын орчин үеийн хүүхдийн уран зохиолыг үндэслэгчид, гол төлөөлөгчид, зохиолчдын товч намтар, монголын хүүхдийн уран зохиолын алтан сан хөмрөгөөс дээж болох 5 тууж, 1 жүжиг, 2 найраглал, 60 гаруй өгүүллэг, 80 гаруй шүлгийг оруулжээ.

83.8я2


Б-33

/НУН унш-3, ГНОФ-3, Лав-1ш/

Т-18414-18416



Бөрт С. **Сонгодог 100 зохиолч**: Үе үеийн сонгодог найраг, сод туурвил, шилдэг жүжгийг бүтээгчид. -Анхны хэвлэл / Ред. Д. Галбаатар, Б.Цэнддоо; Орч. Д.Отгонтуяа, Д.Түвшинтөгс. -УБ.: Непко, 2016. -374х. -ISBN 978-99973-66-82-5.



Зохиолч, яруу найрагчдыг юу аугаа болгож байна вэ? Тэр аугаа гэх тодотголыг хэрхэн гаргаж, бас харьцуулав? *Сонгодог 100 зохиолч* бүтээлд бүх цаг үеийн хамгийн нөлөө бүхий зохиолчдын тухай сонирхолтой түүхийг өгүүлэн энэ асуултад хариулахыг зорьжээ. Уг бүтээлд сонгодог 100 зохиолчоос гадна утга зохиолын хөгжилд шинэ өнгө төрх авчирсан 25 зохиолч багтсан байна. Намтар тус бүрд зохиолчийн амьдрал, ололт амжилтыг өгүүлэхийн хамт уран бүтээлийн гараа, замнал болон утга зохиолд оруулсан хувь нэмрийг нь онцолсон ажээ.Чарлз Диккенсээс эхлээд Габриал Гарсиа Маркэс, Хомэр, Виллиам Шекспир хүртэл дэлхийн утга зохиолын суут төлөөлөгчдийн авьяас билэг, алдар цууг өгүүлсэн сонирхолтой намтарыг шимтэн уншаарай. Шинээр Чинуа Ачэбэ, Робэрт Фрост, Артур Миллэр, Тони Моррисон, Жорж Орвэлл, Саппо, Тэннэсси Виллиам зэрэг зохиолчид нэмэгдэж орсон болно.Номд зохиолчдын бүтээлийн жагсаалтаас гадна бусад алдартай хүмүүс тэдний тухай өгүүлсэн "сайшаалын үгс"-ийг ч мөн багтаажээ.

83.3(0)

Дэвт. 1. -374х. /НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24483-24485

Б-67

Дэвт. 2. -370х. /НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24486-24488

Галбаатар Д. **Гэгээг хүсэх, мананд бэдрэх** /Ред. До.Цэнджав, Д.Батжаргал ба бус. –УБ.: Бемби сан, 2016. -252х. -ISBN978-99978-4-103-2.




Профессор Д.Галбаатар амьдралынхаа 40 жилийг ном эрдмийн ертөнцөд өнгөрүүлэхдээ энэ хугацаанд ганц сэдэвт болон уран сайхны шүүмжлэлийн 40-д ном, 180 орчим эрдэм шинжилгээний өгүүлэл, 200 орчим уран сайхны шүүмж, өгүүлэл, мөн тооны ярилцлагыг нийтлүүлжээ. Энэ удаад монгол судлал, монголын утга зохиол, шүүмж судлал, уран бүтээл, монголын түүх, модернизм, монгол бахархалын тухай сэдвүүдээр ярилцсан дан 45 гаруй ярилцлагаас бүрдсэн 3 дахь номоо толилуулж байна.

83.3/1/

Г-19

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Т-18440-18442



Зандраабайдий Х. **Бадмаарсан зул-3: Утга зохиол судлаачийн тухайн дурьдатгал** /Эрхл. Ш.Энхбаяр. -УБ.: Жиком пресс, 2016. -271х. -ISBN978-99962-62-37-1.

Энэ номонд НАХЯ-ны хурандаа Г.Дүйнхэржав, зохиолч Сономбалжирын Буяннэмэх, Мөрдэндэвийн Ядамсүрэн, Ширнэнгийн Аюуш, Цэмбэлийн Өлзий-Очир, Намжилын Хаянхярваа, Далантайн Өлзийбат, Шанжмятавын Гаадамба нарын утга зохиол судлаачдын намтар, уран бүтээлийн талаар дэлгэрэнгүй дурьдсан байна.

83.3(1)

З-27

/ШУС-ХУС-2ш/

Б-24381-24383

Нандинбилиг Г. **Хүүрнэл зохиолыг задлан шинжилж сургахуй** /Ред. С.Дулам, Д.Нямдорж. -УБ.:МИУС Пресс, 2016. -92х. -ISBN 978-99929-67-79-9.(МУИС ШУС Утга зохиол урлаг судлалын тэнхим)



Бичвэр төвт судалгаа нь эхэн үедээ номын хуудсан дээрх үгс,түүний илэрхийлж буй утгад төвлөрч байснаа аажимдаа уншигчийг бүтээж буй нийгэм соёлын хам бичвэрүүдэд чиглэх болов. Утга зохиолын бүтээлийг хэлбэржүүлж буй арга хэрэглүүр нь хэлний энгийн хэрэглээнээс онцгой болохыг тогтолцоотой судалснаар бичгийн боловсрол олгох сургалтанд маш их нөлөөлсөн юм. Уг бүтээлд хүүрнэл зохиолын унших арга зүй, хүүрнэл зохиолын бүтвэр, хүүрнэл зохиолын богино хэлбэрүүд,задлан шинжлэх жишиг асуулт зэрэг агуулгын хүрээнд бичигдсэн.

83.3(1)

Н-28

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Т-18446-18448



Одонтор Ш. **Судлал ба дурсамж: Ш боть** /Ред. Ш.Баттөр. -УБ.:Жиком Пресс, 2016. -212х. -ISBN 978-99973-48-98-2.

Энэхүү ном нь Ш.Одонтор судлал, захидал, дурсамж, Одонтөрийн өдрийн тэмдэглэлийн хуудаснаас гэсэн дөрвөн бүлэгтэй. Утга зохиол судлаачдын мэргэжил нэгт нөхөртэй бичсэн О.Шинэбаяр “Үгийн эрдэнэсийн шинжээч”, Э.Батжавхлан “Ш.Одонтөрийн орчуулгын ур чадварын тухайд”, Б.Мөнхбаяр “ Ш. Одонтөр ба Модернизм Монголд”

зэрэг судлалыг дурдаж болох юм. Мөн түүний бичсэн сонирхолтой судалгаа, шинжилгээ болон дурсамжийг уншихад таатай байх болно.


83.3(1)

О-19

/НУН-унш-4,ГНОФ-3ш/

Б-24429-2443

Сатэрлэнд Ж. **Уран зохиолын товч түүх** /Ред. Б.Цэнддоо; Орч. Ц.Алгирмаа. Анхны хэвлэл. -УБ.: Нэпко, 2016. -293х. -ISBN 978-99973-66-79-5



"Хэрвээ эзгүй арал дээр хаягдах болбол ямар ном авч явах тухай" яригддаг нэвтрүүлгээс санаагаа эхэлсэн энэ бүтээл бол хүн төрөлхтний уран сайхны сэтгэлгээний товч түүх юм. Домог үлгэрийн мөн чанараас эхлээд туульсын бүтээлүүдийн зөвхөн их гүрэн эзэнт улс шинээр мандан бадрах явцыг даган зохиогдож ирсний учир шалтгааныг өгүүлснээс гадна орчин цагийн төрөл жанрын хувьслын учрыг энгүүн сайхнаар тайлбарлажээ. Утга зохиолын ертөнцийг бүхэлд нь тоймлон харсан эл ном номын худалдаа ба зохиогчийн эрхийн асуудлыг эвлэг аятайхнаар тайлбарлажээ. Улмаар орчин үеийн цахим утга зохиолын чиг хандлага болон тодорхой санаа өгөөд уншигчдаар цааш нь бичүүлдэг тийм төрөл жанр гарсныг ч эндээс мэдэж авч болно.

83.3

С-37

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24480-24482



Шархүү А. **Туурвил зүй, орчуулга судлалын зарим асуудал** /Хян. Ш.Тунгалаг. -УБ.: Соёмбо, 2011. -143х. -ISBN 978-99962-2-002-9.

Уг номонд урьд хэвлүүлсэн өгүүллэгүүдээ урлаг, уран зохиолын бүтээлийг туурвих арга ухаан, улс түмнийг соёлын холбоо харилцаагаар нь дамжуулан ойртуулж өгдөг нэгэн зүйл, гүүр болсоор ирсэн орчуулгын эх онолд хамаарагдахаар сэдэвтэйг нь түүн оруулжээ. Энэ үүднээс юуны өмнө Өрнө дахины гоозүйн сургааль, бичих туурвих арга ухааны эх үүслийг тавигчдад багтах эртний Грек улсын гурван их эрдэмтэн Сократ, Платон, Аристотель нарын гүн ухааны үзэл баримтлал, урлах туурвих арга ухааны талаар товч өгүүлсэн байна. Дээрх өгүүллүүд уншигчид, ялангуяа хэл бичиг, уран зохиолын мэргэжилтэн, багш нар, оюутнуудад урлах туурвих арга ухаан, орчуулга судлалын талаарх онол мэдлэгээ сэлбэхэд нь тус дөхөм болох буйзаа.

83

Ш-31

Б-24468-24470

УРАН ЗОХИОЛ

Али Сабахаттин. **Арьсан хүрэмтэй мадонна: Роман** /Турк хэлнээс орч. Г.Сугиррагчаа. -УБ.: Монсудар, 2016. -239х. -ISBN 978-99973-1-364-5.

XX зууны Туркийн хамгийн агуу зохиолчдын нэг Сабахаттин Али энэ романдаа хоёр өөр үндэстэн хүмүүсийн хоорондын хайр сэтгэлийг сэтгэлд хоногштол өгүүлсэн ба 1920-иод оны Берлиний бүжигчин, зураач жүүд эмэгтэй Мариа Пүдерд амьдралынхаа хамгийн агуу хайр сэтгэлийг зориулсан ч золгүй хувь тавилангийн эрхээр хайрт бүсгүйгээсээ хагацаж буй турк залуу Раиф Эфэндигийн тухай бичжээ.

С.Алигийн энэ роман нь бидний хамгийн том хүсэл мөрөөдөл маань биелэхгүй бол бид хэрхэх билээ гэдэг асуудлыг гүнзгийрүүлэн авч үзсэнээрээ онцлог ажээ.

84/5Ту/-44

А-46

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24577-24579



Алтан Ордоны яруу найраг /Орч. Ж. Нэргүй. -УБ.: Жиком, 2013. -177х. -ISBN 978-99973-44-07-6.



Монгол уншигч нарын гар дээр анх удаа ирж буй энэ түүвэрт орсон нэр нь мэдэгдэх хийгээд үл мэдэгдэх найрагчдын гоо хүүхнүүдийг улам гоёчилсон янагийн дуоллуудын хажуугаар бас эзэд, ноёдоо алдаршуулсан магтуунууд байгаа нь хамаагүй, зүйрлэл, хэтрүүлэг нь хэтийдсэн, агуулгын давталт ихтэй байх нь ч хамаагүй, гагцхүү тэр үеийн юмыг тэр үеийнхээр нь л дэнслэн үзэх ёстой болохоор одоогоос 700 орчим жилийн өмнө Алтан Ордоны Улсын соён гэгээрүүлэгчид бичгийн болоод хийсвэр сэтгэлгээний гайхалтай өндөр түвшинд уран бүтээлээ туурвиж байсныг эрхэм уншигч та эндээс мэдэх болно.

84(5)-5

А-48

/НУН-унш-3ш/

Б-24421-24422

Боланьо Р. **Люмпены тууж** / Англи хэлнээс орч. Т. Ариунсанаа. -УБ.: Монсудар, 2016. -104х. -ISBN 978-99973-1-363-8.


Роберто Боланьо, Габриель Гарсиа Маркесаас хойш олон улсад хамгийн их алдаршсан зохиолч гэж үзэх нь элбэг. *Догшин мөрдөгчид*, 2666 хэмээх нүсэр хоёр романаараа нэр хүнд нь түгсэн түүнийг постмодеризмын тэргүүн эгнээний зохиолч гэж үздэг. Боланьогийн богино хэмжээний сод бүтээлүүдийн нэг болох *Люмпены тууж* эцэг эх нь замын ослоор гэнэт нас барсны дараа өнчирч хоцорсон эгч дүү хоёр, томоос том Ром хотод хэрхэн аргаа олж, амьжиргаагаа залгуулж буй тухай өгүүлнэ. Энэ орчин үеийн “төлөвшилийн” романаараа Боланьо, порнограф, биеэ үнэлэлт зэрэг эмзэг сэдвийг зоригтойгоор хөнджээ.

84(7АНУ)-4

Б-55

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24525-24527



Войнович В. **Цэрэг Иван Чонкины амьдрал хийгээд ер бусын адал явдал** /Орч. Ж.Нэргүй; Бэлт. Б.Баярбаатар. -УБ.:Жиком, 2016. -336х. - ISBN 978-99973-73-86-3.

Уг номын зохиогч В.Н.Войнович "Итгэл найдварын түвшин", "Хөшөөн суртаал", "Москва 2042", "38840 тоот хавтаст хэрэг", "Өөрийн хөрөг. Миний амьдралын роман" зэрэг 20 гаруй зохиол бүтээл туурвисанаас хамгийн алдартай нь энэхүү "Чонкин..." хэмээх гурамсан роман бөгөөд үүгээр нь Орос болон дэлхийн хэд хэдэн орнууд уран сайхны кино хийсэн байдаг. Энэхүү романаас уншигч авхай та Зөвлөлтийн нэгэн үеийн хүмүүсийн алба, амины жишээн дээр тулгуурласан, харгис хатуу үзэл суртлыг хоржоонтой хэлбэрээр бичсэнийг уншиж, тэр цагийн арчаагүй мэт үйл явдлуудын халуун мөрөөр аялах болно.

84(2Орос)-44


В-61

/НУН-унш-2ш/

Б-24413-24414

Есенин С. **Сонгодог шүлгүүд** /Орч. Ж.Нэргүй. -2 дахь хэвл. -УБ.: Жиком, 2016. -183х. -ISBN 978-99962-58-28-2.

Орчуулагч Ж. Нэргүй энэ удаа Оросын алдарт яруу найрагч Сергей Есениний сонгодог шүлгүүдийг орчуулан хүргэж байна. Тэрээр бүтээлдээ сонгодог шүлгүүдийг нь “Амин булаг буюу балчир насны шүлгүүд”, “Цэнхэрхэн үдэш буюу идэр насны шүлгүүд”, “Перс аялгуу буюу төгс насны шүлгүүд”, “Цасан хөндий буюу насан эцсийн шүлгүүд” хэмээх хэсгүүдэд хуваан оруулсан ба “Танхай эрийн өчил”, “Анна Снегина”, “Сүг сүүдэр” хэмээх алдарт найраглалуудыг орчуулан уншигчдадаа хүргэж байна.



84(2Орос)-5
Б-74

/НУН-унш-3ш/

Б-24415-24416



Клар К. **Үнсэн хот**: Үхлийн зэвсэг хоёрдугаар дэвтэр / Ред. Э.Түвшинбаяр, Ч.Мөнхтуяа; Орч. Ж.Заяажаргал. -УБ.:Монсудар, 2015. - 416х. -ISBN 978-99973-1-213-6.

Клари Фрэй зөвхөн өөрийн хуучин, хэвийн амьдралаа буцааж авахыг хүсэж байлаа. Хэрэв чи нэг л өдөр чөтгөрүүдийг устгах үүрэгтэй "Сүүдрийн ангууч" гэдгээ мэдэж, хүн чоно, цус сорогч, шидтэнг харж, эх чинь шидэт шившлэгийн улмаас ухаангүй болбол хэвийн амьдралаа хүсэхгүй гэж үү? Клари дотны найз Саймонтойгоо цагийг өнгөрүүлмээр байвч Сүүдрийн ангуучид, тэр дундаа ах дүүс гэдгээ саяхан мэдсэн түүний царайлаг хэр нь үргэлж цухал төрүүлэм аашилдаг ах Жейс нь түүнийг хориглоно. Мөн Кларигийн ээжийгээ аврах ганц арга зам бол өөрийн төрсөн эцэг болох Сүүдрийн ангуучдаас урван тэрсэлсэн Валентиныг барих ажээ. Энэ үед хоёрдахь Үхлийн зэвсэг хулгайд алдагдаж, Инквизитор энэ хэрэгт Жейсийг сэжиглэнэ. Тэр үнэхээр бүгдийн итгэлийг эвдэж, өөрийн эцэгт тусалсан болов уу?

84(7АНУ)-44

К-51

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24552-24554

Клар К. **Шилэн хот**: Үхлийн зэвсэг гуравдугаар дэвтэр / Ред. Э.Түвшинбаяр, Ч.Мөнхтуяа; Орч. Ж.Заяажаргал. -УБ.:Монсудар, 2015. - 496х. -ISBN 978-99973-1-207-5.


Ээжийнхээ амь насыг аврахын тулд Клари Фрэй Сүүдрийн ангуучдын эх орон болох Шилэн хот руу явна. Энэ хотод зөвшөөрөлгүй очих нь хууль зөрчсөн хэрэг бөгөөд уг хуулийг зөрчвөл үхлийн ял оноодог ёстой. Гэвч энэ бүхэн Клариг зогсоож чадсангүй. Харин үүнээс илүүтэйгээр Жейс түүнийг энэ хотод байхыг хүсээгүй нь, мөн нарны гэрлээс айдаггүй цус сорогчийг хардаж сэжиглэсэн Сүүдрийн ангуучид Саймоныг шоронд хорьсон нь түүнд хүнд цохилт боллоо. Энэ үеэр Клари нууцлаг Сүүдрийн ангууч Себастьянтай танилцана. Валентин Сүүдрийн ангуучдыг устгахаар Чөтгөрийн армийг цуглуулжээ. Сүүдрийн Ангуучдын аврагдах цорын ганц зам бол Доод ертөнцийнхөнтэй холбоотон болох. Гэвч Сахиусан тэнгэрийн удам ба Доод ертөнцийнхөн эцсийн эцэст эртний үзэн ядалтаа зогсоож хамтдаа тэмцэж чадах болов уу? Мөн Клари шинээр илэрсэн гайхамшигт чадвараа БҮХНИЙГ аврахад ашиглаж чадах болов уу?

84(7АНУ)-44

К-51

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24555-24557



Коллинз В. **Саран чулуу** /Англи хэлнээс орч. Л. Баярмандах; Ред. Д.Сайнзаяа. -2 дахь хэвлэл. -УБ.:Адмон, 2009. -506х. -ISBN 978-99962-3-654-9.

Английн алдарт зохиолч Вилки Коллинз нь адал явдалт зохиолын "эцэг" хэмээн зүй ёсоор тооцогддог. Энэ номонд Энэтхэгийн сарны бурхны магнайд байсан очир алмазтай холбогдон үүссэн адал явдлыг маш сонирхолтойгоор өгүүлсний зэрэгцээ английн нийгмийн амьдралын шударга бус тал, хөрөнгөтнүүдийн "сайн үйлс" гэгчийг хуурмаг, хоёр нүүрт чанарыг хурцаар шоглон илчилжээ. Дэлхийн түүхэнд анхны детектив зохиол гэдгээрээ танигдсан уг ном тухайн үеийн зан заншил, онгон шүтээн, эртний бэлгэдэл, адал

явдлын өрнөлтэйгөөр өгүүлэгдсэн нь өнөөг хүртэл дэлхийн сая сая уншигчдын сонирхлыг татсаар байгаа билээ.

84(4ИхБр)-44

К-60

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24492-24494

Күнзийн барьсан зоог /Орч. А.Уранчимэг; Ред. Б.Төгсжаргал, Э.Эрдэнэсүвд. –УБ.:Адмон, 280х. –ISBN 978-99962-62-42-5.

Энэхүү бүтээлд орчуулагч Хятадын гурван үеийн зохиолчдын бүтээлийг сонгон авч уншигчдадаа хүргэж байна. Хятадад ардчилсан хувьсгал эхлэхийн өмнөх үеийн уран зохиолын төлөөлөл болгож, 1930-аад оны үед зохиол бүтээлээ туурвиж байсан алдарт зохиолч Гуо Мөруогийн бүтээлээс оруулсан ба мөн түүхэндээ Хятадын ард түмэнд асар их зовлон зүдгүүр авчирсан “Соёлын хувьсгал”-ын арван жил дуусч, хүмүүс энх амгалан амьдралд шилжин орж эхэлж үеийн зохиолчдын бүтээлийн төлөөлөл болгож Чен Көсюний “Хөхөөн дуу”-г сонгосон юм.

84(5Хят)

К-96

/НУН-унш-3ш/

Б-24419-24420



Лагеркранц Д. **Аалзны торонд орооцолдсон охин**: Стик Ларссоны миллениум цувралын үргэлжлэл /Ред. Ч.Баасанжаргал, Б.Төмөр; Орч. Ц. Бямбацогт. -УБ.: Адмон, 2016. -436х.-ISBN 978-99973-1-311-5.

Давид Лагеркранц нь гэмт хэргийн сэдвээр бүтээлээ туурвидаг, Шведийн алдартай зохиолч билээ. Тэрбээр Алан Тюрингийн үхлээс сэдэл аван Вилмслоу дахь бүтэлгүйтэл номыг бичсэн бөгөөд “Намайг Златан Ибрахимович гэдэг” хэмээх бэстсэллер болсон намтар номын зохиогч юм. Энэхүү адал явдалт зохиол нь “Луун шивээст охин”, “Галаар наадсан охин”, “Зөгийн үүр бусниулсан охин” хэмээх миллениум цувралын үргэлжлэл болно.

84(4ИхБр)-44

Л-13

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Т-18467-18469

Лондон Ж. **Саран хөндий** /Орос хэлнээс орч. Д.Лхамжав; Ред. Б.Сувддулам. -УБ.: Монсудар, 2009. -551х. -ISBN 978-99962-3-653-2.


Жек Лондон (1876-1916) хүнд хүчир ажил хийж өсвөр насаа өнгөрүүлсэн гэдэг. Түүнийг 20 нас хүрэх үед, Аляскийн зүүн хэсгийн бүс нутаг болох Клондайкт алтны орд нээгдсэн тул олон олз хайгсдын адилаар залуу эр тийш зорьжээ. Тэнд Жек Лондон олз омогтой ажиллаж чадаагүй ч буцахдаа Аляскийн өргөн уудам нутгийг хөндлөн гулд аялж, эндхийн хүн зон, нутаг оронтой танилцсан нь түүнд жинхэнэ “эрдэнэсийн уурхай” олсон явдал болжээ. Тодруулбал, Аляскаас л Жек Лондон алдартай олон зохиолынхоо гол санааг шүүрдсэн юм. Билл, Саксон нар эгэл жирийн ажилчин залуус бөгөөд өөрсдийн үнэнч, шударга хөдөлмөрөөр мөрөөдлийнхөө амьдралыг босгох гэсэн ирмүүн хүсэлтэй хос билээ. Тэд хүн ам төвлөрсөн их хотод хэсэг хугацаанд амьдрахдаа өөрсдийг нь сорих олон саад бэрхшээлтэй тулгарна. Залуу хосод энэ бүхэнтэй тэмцэх, түүнийг ялан дийлэх их хүчийг хөршгүй хайр сэтгэл нь өгч байв. Эцэст нь Билл, Саксон хоёр нийгмийн хамгийн муу муухай бугшсан нүргээнт хотоос жинхэнэ аз жаргалаа олохгүйг ухаарна. Тэдний хөдөлмөрийг үнэнч шударгаар үнэлж, үр шимийг нь өгнө гэдэгт итгэсэн хос их хотыг орхин, байгалийн онгон зэлүүд нутгийг зорихоор шийдэж хөлгийн жолоо зална.


84(7АНУ)-44

Л-75

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24489-24491





Луо Гуаньжин **Гурван улсын үлгэр**: 3 боть /Орч. Д.Болдбаатар; Хян. Б.Билгүүн. -УБ.: Соёмбо принтинг, 2015. -772х. -ISBN 99962-2-235-1.

Хятадын эртний ба сонгодог уран зохиолын бүтээлүүдээс Хятадад төдийгүй дэлхий дахинаа түгэн дэлгэрсэн суут туурвилуудын манлайд "Си Ю Зи" буюу "Тансан ламын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл", "Шуйху Жуань" буюу "Хүйтэн уулын бичиг", "Саньгуо Янь И" буюу "Гурван улсын үлгэр", "Хунлоу Мөн" буюу "Улаан асрын зүүд" хэмээх 4 роман ордог. "Гурван улсын үлгэр" зохиолын гол өгүүлэмжийг товчхон хэлбэл бүхэлдээ Хятадын түүхийн нэн дуулиантай зурвас үеийг тусган үзүүлжээ. Шар алчууртны бослогыг даралцсан Сүн Зян хэмээгч нь Хөх мөрний дунд, доод урсгал хавийн бүс нутагт өөрийн улсыг байгуулж Ү хэмээн нэрийдэв. Баруун өмнөд нутагт ноёрхлоо тогтоосон Лю Бэй 221 онд өөрийгөө эзэн хаанд өргөмжлөн Шу улсыг байгуулжээ. Хань улсын төв хэсгийг авч үлдсэн Цао Цаогийн хүүгийн Цао Пэй 220 онд Вэй хэмээх шинэ төр үүсгэн хаанчлан суужээ. Энэ гурван улсын хооронд нэгэн жарны туршид дээд эрх мэдлийн төлөө тэмцэл өрнөж, 280 онд эл гурван улсыг нэгтгэн захирсан Зинь улс байгуулагдсанаар төгсгөл болсон юм. Ийнхүү Шар алчууртны бослого эхэлсэн 189 оноос 280 он хүртэл эл бүхий л дуулиант хэрэг явдлыг хамарсан нэгэн жаран илүү хугацааны түүхийг Луо Гуаньжун энэхүү бүтээлдээ дүрслэн өгүүлсэн байна.

84(5Хят)

Л-82

/НУН унш-4, ГНОФ-3, ШУС-ХУС-1ш/

Б.1. 772х. Б-24369-24371

Б.2. 692х. Б-24372-24374

Б.3. 736х. Б-24375-24377

Маркес Г.Г. **Тахлын үеийн дурлал** / Испани хэлнээс орч. Б.Нямдорж. -УБ.:ОБ Капитал Пресс, 2016. -460х. -ISBN 978-99973-40-09-2.

Хайрын тухай бичихээс хэзээ ч уйддаггүй Габо энэ романаа 1985 онд хэвлүүлжээ. Нобелийн шагналт Габриель Гарсия Маркесийн хоёр оргил бүтээл байдгийн нэг нь бөхөшгүй, итгэмээргүй, боломжгүй мэт ч эцэстээ боломжтой мэт санагдах агуу, гайхалтай хайрын тухай өгүүлдэг “Тахлын үеийн дурлал” юм. Тэрээр өөрт нь Нобелийн шагнал авчирсан “Зуун жилийн ганцаардал”-аасаа ч илүү энэ романдаа дуртай гэдгээ нэгэн ярилцлага дээр онцолж байсан юм.

84(4Исп)-44

М-26

/НУН-унш-4, ГНОФ-3ш/



Б-24477-24479



Мартин Ж. **Хаадын хагарал**: Гал мөсний дуун цувралын хоёрдугаар дэвтэр / Ред. Ч.Мөнхтуяа, Э.Түвшинбаяр, Д.Мөнхцэцэг; Орч. Н.Энхнаран. -Анхны хэвлэл. -УБ.:Адмон, 2014. -605х. -ISBN 978-99973-1-091-0.

Зохиолын үйл явдал Долоон ханлиг буюу Вестерос, чөлөөт хотуудаас бүрдэх Эссос хэмээх хоёр тивд өрнөнө. Долоон хүчирхэг овог удмыг нэгтгэн захирч байсан Роберт Баратеон хаан бусдад хорлогдон нас барснаар төмөр хаан ширээний төлөөх цуст тэмцэл Долоон ханлиг даяар дэгдэнэ. Энэ үеэр мөн Долоон ханлигийг хар шид, аймшигт зэрлэгүүдээс хамгаалан босгосон хананы цаана муу ёрын хүч хуралдан цугларч эхэлдэг. Харин Уйтан тэнгисийн тэртээх Эссос тивд нэгэн цагт Долоон ханлигийн төмөр хаан ширээнд заларч явсан Таргарианы сүүлчийн удам Дэйнерис хууль ёсны хаан ширээгээ буцаан авахаар тэмцэж буй тухай өгүүлнэ.

84(7АНУ)-44

М-27

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Т-18476-18478

Мартин Ж. **Илдний шуурга** : 1. Төмөр ба цас. Гал мөсний дуун цувралын гуравдугаар дэвтэр (I хэсэг) /Ред. Ч.Мөнхтуяа, Э.Түвшинбаяр; Орч.Н.Энхнаран. -Анхны хэвлэл. -УБ.: Адмон, 2014. -428х. -ISBN 978-99973-1-141-2.



Өвөл хаяанд ирж, умардын салхи догшин араатан мэт айсуу. Цусан дайсагнал, үймээн самуунаас болж Долоон хаант улс хэдэн хэсэг хуваагдана. Төмөр хаан ширээний төлөө тэмцэж байсан 5 хүнээс нэг нь амь үрэгдэх бол нэг нь хүнд байдалд орно. Харин төмөр хаан ширээнд Жоффри Баратеон заларснаар түүний заналт дайсан, авга ах Станнис Лууны цохионд Төмөр хаан ширээний төлөө дахин нэг дайралт хийхээр сэтгэл шулуудна. Умардын хаанаас өргөмжлөгдсөн Роб Старкийн газар нутаг руу харанхуйн ид шид, зэрлэгүүдийн асар том арми дайрахаар бэлтгэнэ. Харин Робб өөрийн тугчдын хамт Риверраныг барьж байсан ч удахгүй...

84(7АНУ)-44

М-27

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Т-18470-18472



Мартин Ж. **Илдний шуурга** : 2. Цус ба алт. Гал мөсний дуун цувралын гуравдугаар дэвтэр (II хэсэг) /Ред. Д.Мөнхцэцэг, Э.Түвшинбаяр; Орч.Н.Энхнаран. -Анхны хэвлэл. -УБ.: Адмон, 2015. -416х. -ISBN 978-99973-1-142-9.

Цагаан сахалт Арстан асар луу орох үүдэн дээр зогсоход Хүчит Белвас ойролцоох өвсөн дээр завилаад, тавагтай инжир идэж суув. Аян замд Дэйниг хамгаалах үүрэг тэдэнд оногджээ. Дэйнерист цусан морьтнуудын зэрэгцээ кос нь болох Жого, Эгго, Ракаро нар байсан ч одоохондоо тэд хүмүүсийг нь хамгаалахын тулд дотракичуудыг захирах хэрэгтэй байв. Түүний каласар өчүүхэн жижиг гуч орчим морьтой дайчин байснаас ихэнх нь гэзгээ сүлжээгүй хөвгүүн болон бөгтөр нуруутай өвгөд аж. Гэсэн ч бүгд морьтой агаад Дэйни тэднээс холдож зүрхэлсэнгүй. Ансаллидууд сэр Жорагийн хэлснээр энэ ертөнцийн хамгийн сайн цэрэг байж болох ч түүнд тагнуул туршуул морьтнууд хэрэгтэй байлаа...

84(7АНУ)-44

М-27

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Т-18473-18475

Оруэлл Ж. **Амьтны ферм**: Улс төрийн элэглэл /Орч. О.Тогоохүү; Ред. Д.Ууганцэцэг. -УБ.: Монсудар, 2005. -96х. -ISBN 978-99973-1-264-8. (Дэлхийн сонгодог зохиол)



1930-аад оноос Барууны ертөнцийн олон зохиолч Марксимзд талтай хандах болжээ. Фашизмыг эсэргүүцэх үзэл Эдийн засгийн их уур амьсгалтай хосолж, коммунист дэглэмийн доорхи амьдралын жинхэнэ нүүр царайг олж харахад садаа болсон юм. Зөвлөлт Холбоот Улсын дотор ч эрүүл сэтгэлгээний дуу хоолойн дарагдаж, улс төрийн эрхшээлд оюунлиг сэхээтнүүд бүрнээ автах болсон энэ үеийг даван туулахад амаргүй байлаа...


84(4ИхБр)-44

О-47

/НУН-унш-4, ГНОФ-3, ШУС-ХУС-2ш/

Б-24386-24388

Оруэлл Ж. **Мянга есөн зуун наян дөрөв** / Орч. Д. Чулуундорж; Ред. Д. Сайнзаяа. -УБ.: Монсудар, 2008. -302х. -ISBN 978-99973-1-263-1.



Мянга есөн зуун наян дөрөв" бол хар дарсан зүүд мэт айдас хүйдэс ноёлсон, бүхнийг эрхшээгч цагдаагийн улс ирээдүйд тогтож буй тухай өгүүлсэн, зөгнөлт роман юм. Оруулл тоталитар засаглалын аймшигт урхагийг зөгнөн хэлэх маягаар сэрэмжлүүлэхийг зорьсон хэрэг л дээ. Энд дүрсэлснээр суртал ухуулга явуулсныхаа үрээр тухайн улс бүх иргэнийхээ амьдрал ахуй болоод бодол санаанд бүрэн хяналт тогтоогоод зогсохгүй, тэднийг өөрсдийнхөө бодлогын үүднээс л үг хэлдэг, бодож сэтгэдэг болгох арга журмыг хэрэгжүүлж байгаа нь дэлхийн утга зохиолд хэзээ ч хөндөгдөөгүй, ийм нарийн ширийн задлан дүгнэгдээгүй сэдэв юм. Гол баатар Уинстон Смит сэтгэхүйн цагдаагийн газарт баривчлагдах ба түүний өдүүлсэн гэмт хэрэг гэвэл нийтээр хүлээн зөвшөөрөгдөөгүй итгэл үнэмшилтэй болсон мөн хайр дурлалаа нуун хамгаалсан явдал ажээ. Энэ роман тоталитар нийгмийн тогтолцоог үзэл санааны нь хувьд нэгмөсөн булшилсан, үгийн урлагийн гайхамшигт турвил билээ.

84(4ИхБр)-44

О-48

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24528-24530

Пушкин А.С. **Шүлэг найраглал** / Орч. С.Дондог; Орч. Ред. А.Шархүү, Г. Буянтогтох.-УБ.:Адмон, 2016. -296х. -ISBN 978-99973-0-901-3.

Уг номыг эрхлэн хэвлүүлэгч С.Дондог багшлах, эрдэм судлалын ажлын зэрэгцээ өнгөрсөн зууны 60, 70-аад оны заагаас эхлэн өнөөдрийг хүртэл уран зохиолын орчуулга оролдож иржээ. Өнгөрсөн хугацаанд А.С.Пушкин, А.А.Ахматова, Расул Гамзатов, Кайсын Кулиев, Роберт Бөрнс, Франсуа Вийон нарын яруу найрагчдын шүлэг, найраглалаас орчуулж, тус бүр бие даасан түүврүүд, сүүлийн 5 жилд Ханс Христиан Андерсены урьд өмнө монгол хэлнээ орчуулагдаагүй байсан хорин таван үлгэрийг багтаасан түүвэр, мөн "Азтай Петь хүү" тууж, Л.Кэрроллийн "Алиса бээр толины чанадад зорчсон ану", Оросын яруу найрагч М.Ю.Лермонтовын мэндэлсний 200 жилийн ойд зориулан, түүний цөөвтөр шүлэг, шүлэглэсэн тууж, найраглалаас бүрдсэн шүлэг, найраглалын жижиг түүврийг тус тус орчуулан ном, түүврүүд болгон хэвлэн нийтлүүлсэн байна.

84(2Орос)-5

П-94

/НУН-унш-3, ШУС-ХУС-5ш/

Б-24384-24385



Рид М. **Хурлийз бүсгүй** /Орч. Л.Баярмандах; Ред. Д. Сайнзаяа. -3 дахь хэвл. -УБ.: Адмон, 2016. -363х. -ISBN 978-99973-1-064-4.

Английн зохиолч Томас Майн Рид "Хурлийз бүсгүй" романаа 1856 онд бичжээ. Зохиолд үзэсгэлэн гоо залуу охид, үнэнч хайр сэтгэл, гайхашигтай сонин адал явдлын тухай өгүүлдэг. Хүн хэдийгээр эцэг эхээс эрүүл саруул, гоо сайхан, цэлмэг ухаантай төрөвч хэрэв боол л бол түүнд ямар гашуун хувь заяа оногдож байсныг энэ зохиолд тод дүрсэлжээ.

Зохиолын гол баатар ариун шударга залуу эр санамсаргүй тохиолдлоор баян чинээлэг, гоо сайхан креол бүсгүй Ежээни Безансоны амийг авардаг. Залуу эр Ежээни Безансоны боол, гоо үзэсгэлэнт хурлийз бүсгүй Аврорад сэтгэл алдан дурлаж зохиолын адармаатай үйл явдал цааш өрнөнө.

84(4ИхБр)-44

Р-49

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24501-24503

Свифт Ж. **Гулливрийн аялал** /Орос хэлнээс орч.Ц.Шүгэр; Ред. Д. Сайнзаяа. -2 дахь хэвл. - УБ.: Адмон, 2013. -145х. -ISBN 978-99962-3-656-3.(Дэлхийн сонгодог зохиол)



Ирландын Дублин гэсэн нэр магадгүй Жойсыг санагдуулж болох юм. Гэхдээ Жонатан Свифт, мөн “Гулливрийн аялал”-ыг сануулах юм шүү. Анх эмч байгаад эцэстээ хөлөг онгоцны ахмад болсон Лэмюэль Гулливрийн аялалын тухай ном бичиж тэр нь хардлага сэрдлэг дагуулж, тэр чинээгээрээ дэлхийн сонгодог зохиолын хүрээ рүү орж чадсан юм. Өөрөөс нь хэд дахин том хийгээд хэд дахин жижиг одой хүмүүсийн оронд хийж буй Гулливрийн аялал өнгөц харахад хөгжилтэй, инээдмийн, хүүхдийн зохиол мэт санагдах ч тухайн үеийн Английн нийгмийг ёгтлон бичсэн нь үнэнтэй. Гулливр аялалынхаа төгсгөлд энгийн хүний ертөнцөд ирээд хүн ерөөсөө өлийж биш эс бол хэт тонгойж биш шулуун харах нь сайхан юм гэж хэлдэг. Энэ нь баяд ноёд, ядуу доодсын ялгаа заагийг гаргаж өгсөн хэрэг. Анх 1726 онд бичигдсэн цагаасаа эхлэн дэлхийн уран зохиолын үнэт өвийн жагсаалтанд байсаар, бүх насны уншигчдад үнэ цэнээ хадгалан үлдсэн гайхамшигт бүтээл.

84(4ИхБр)-44

С-40

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24504-24506



Соосэки Н. **Боччан** /Япон хэлнээс орч. Ц.Онон. -УБ.: Монсудар, 2016. - 184х. -ISBN 978-99973-1-368-3.

Японы утга зохиолыг орчин үежүүлэхэд Нацүмэ Соосэкигийн гүйцэтгэсэн үүрэг нь Герман, Английн утга зохиолыг шинэтгэхэд Кафка, Жеймс Жойс нарын тус тус гүйцэтгэсэн үүрэгтэй дүйцнэ. 1906 онд бичигдсэн *Боччан* хошин роман, өнөөдөр ч гэсэн Японы сургуулийн уран зохиолын хичээлийн хөтөлбөрт багтдаг ажээ.Энэ романд, том хотод багшийн мэргэжлээр суралцсанахаа дараа хөдөө тосгонд хуваарилагдсан залуу багшийн тухай өгүүлнэ. Тэрээр багшийн ажилдаа төвлөрөхийг хүссэн ч тосгоны сургуулийн багш нарын эрх мэдлийн өрсөлдөөн, эргэн тойрны жигшил зэвүүцлийг няцаан тэмцэхэд хамаг эрч хүчээ зарцуулахаас өөр аргагүйд хүрнэ.Боловсрол гэдэг ердөө мэдлэг түгээхээр хязгаарлагддаггүйг, багш хүн өөрөө ёсзүйн хэм хэмжээнд захирагдахгүй бол түүний заасан мэдлэг ямар ч үнэ цэнгүй болохыг энэ романд харуулжээ.

84(5Яп)-44

С-58

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24510-24512

Твен М. **Жонон гуйлгачин хоёр** /Ред. Д. Сайнзаяа; Хян. Л. Роозон. - УБ.: Монсудар, 2009. -279х. -ISBN 978-99962-0-792-1.



Сайхан муухай хоёр, харгис энэрэнгүй хоёр яаж зэрэгцэн оршдогийг зохиолч Том Кенти, Эдуард Тэодор хоёрын дүрээр харуулжээ. Ядуу гэр бүлд төрсөн Том Кенти өөртэй нь усны дусал мэт адилхан төрсөн ханхүү хорвоо дээр байдаг чинээ төсөөлөө ч үгүй явжээ. Ноорхой хувцас өмсөн гуйлга гуйдаг Том хүү жинхэнээсээ ханхүүг үзэх юмсан, цэвэр сайхан хувцас өмсөхсөн гэж мөрөөддөг байсан нь хувь заяаны тохиолдлоор биелжээ. Ханхүү Эдуард ядуу хүү Том хоёр санамсаргүй байдлаар танилцан улмаар хүүхдийн гэнэн зангаар хувцсаа солин өмссөнөөс болж тэдний хувь заяа солигддог. Ингээд Том Кенти хааны ордонд олон адал явдалтай учирч ханхүү Эдуард тэнэмэл гуйлгачны хэцүү амьдралыг туулах болжээ.

84(7АНУ)-44

Т-34

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24531-24533

Толстой Л. **Крейцерийн сонат** /Орос хэлнээс орч. Ч.Баатар. -УБ.: Монсудар, 2016. - 152х. -ISBN 978-99973-1-321-8.

Толстойн *Иван Ильичийн үхэл* туужаас гадна олонд хамгийн их алдаршсан богино хэмжээний бүтээл нь *Крейцерийн сонат* юм. Энэ тууждаа утга зохиолын мөнхийн сэдэв болох хайр дурлал, гэрлэлт, хардалтын тухай өгүүлжээ. Гэхдээ Толстой байдаг л нэг хайрын түүхийг бичсэнгүй. Тэрээр эдгээр сэдвийг задлан шинжилж нийгмийг сэрээх, өдөөхөд ашигласан байна. Хувь хүний аз жаргал, зовлон гуниг нь нийгмийн нөхцөл байдлаас хамаардаггүй гэж боддог хүн бүр алд дэлэм эндүүрч байгааг энд дурдах нь зүйтэй болов уу.



84(2Орос)-44


T-47

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24516-24518

Тургенев И.С. **Эцэг хүүхэд** /Орч. Ш.Очирбат. -УБ.: Монсудар, 2016. - 280х. -ISBN 978-99973-1-252-5.

Уг роман шинэ ба хуучин үеийн үзэл санааны тэмцэл, зөрчлийг гүнзгий тусган харуулсан нь эдүгээ ч үнэ цэнээ алдаагүй хэвээр байгаа ба зохиолын үйл явдал хоёр үеийн үзэл санааны зөрчил тод илэрсэн XIX зууны 60-аад онд өрнөнө. Уг бүтээлийн гол санаа нь бүх нийтээрээ харилцан дайсагналцах нь утга учиргүй бөгөөд бүгдэд тохирох шинэ үзэл санааг бий болгох хэрэгтэй, эс тэгвэл мөхөлд хүрнэ гэдгийг харуулсанд оршино.



84(2Орос)-44

T-68

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24495-24497



Хаан сургаал: Эртний Монгол уран зохиолын унших /Эмхт. Б.Хишигсүх. -УБ.:Хайтан, 2016. -194х. -ISBN 978-99978-4-223-7.

Монголын эртний сонгодог зохиол бүтээлийг цуглуулах, эмхэтгэн цэгцлэх ажлыг академич Ц.Дамдинсүрэн эхлүүлэн “Монгол уран зохиолын дээж бичиг зуун билиг оршибай”, “Монголын уран зохиолын тойм” /I,II,III/ бүтээлүүдийг гаргасан билээ. Энэхүү судалгааны ажлыг үргэлжлүүлэн доктор, дэд профессор Б.Хишигсүх багш маань “Чингис хааны билиг сургаал”-аас эхлэн “Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал” хүртэл долоон зуу гаруй жилийн туршид зохиогдсон сор бүтээлүүдээс дээжлэн, судлан цуглуулж, монгол бичгээр хэвлэгдсэн, олдоц муутай зарим сураалыг оруулан эмхэтгэж судалгааны эргэлтэнд оруулж буйн нэн ач холбогдолтой болсон. Үнэ цэнэтэй бүтээлүүдийг дээжлэн “Хаан сургаал-1” 2,3,4 цоморлигууд гарсан ба уншигч таны гар дээр цоморлиг 5 хүрч байна.

84(1)2

X-10

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24534-24536

Хэмингуэй Э. **Өвгөн тэнгис хоёр** /Орос хэлнээс орч. Ц.Сүхбаатар. -УБ.: Монсудар, 2016. -122х. -ISBN 978-99973-1-366-9.

Эрнест Хемингуэй энэ тууждаа нэг талаас байгаль, хүн хоёрын байнгын тэмцлийг харуулсан бол нөгөөтэйгүүр цөхрөл, итгэл найдварын тухай өгүүлжээ. Америкийн алдартай зохиолчийн амьд ахуйдаа хэвлүүлсэн хамгийн сүүлчийн бүтээл болох энэ туужаас Хемингуэйн алдар нэрд хүрсэн учир шалтгаан тус бүрийг олж харах боломжтой. Минималист хэр нь хүчтэй бичлэгийн хэв маяг, Хемингуэйн зохиолын үлгэр жишээ болсон, хамгийн



хэцүү цаг мөчид ч хүн байхын нэр төрөө хадгалж үлддэг гол дүр бүхий энэ бүтээлээрээ зохиолч өмнөх бүх бүтээлээ давж гарчээ. Хемингуэйн аль ч зохиол, бэлгэдлийн утга, олон янзаар тайлбарлаж болохуйц шинж чанараараа энэ туужтай эн зэрэгцэхгүй Хемингуэйг 1954 онд Нобелийн шагнал хүртэхэд ньтуужийн нөлөө хамгийн их байсан юм.

84(7АНУ)-44

Х-32

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24498-24500



Энхболд Д. **Паанан** /Хян. Д.Эрдэнэбаяр, Д.Энхтүвшин. -УБ.:Мөнхийн үсэг, 2016. -374х. -ISBN 978-99973-79-92-4.

Доржзовдын Энхболдын “Бүйлс дахин цэцэглэнэ”, “Паанан”, “Хүн байхад юу хэрэгтэй вэ”, “Казиног номхтгосон түүх”, “Өвс ногоо аниргүй” зэрэг зохиолууд нь хэвлэгдсэн. “**Паанан**” хэмээх энэхүү зохиолд “Соёо”, “Паанан”, “Миний Нарансолонго” зэрэг өгүүллэгүүд нь багтсан.

84(1)-44

Э-66

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24457-24459

Яао Ч. **Хосгүй үзэсгэлэнт хэлгүй эхнэр** /Орч. А.Уранчимэг; Ред. Ц.Хасбаатар, Б.Төгсжаргал, Э.Эрдэнэсүвд. -2 дахь хэвл. -УБ.: Жиком, 2016, -282х. -ISBN 978-99962-1-980-1.

Монголын үндэсний радиогийн орчуулагч А.Уранчимэг Тайваны зохиолч эмэгтэй Чюн Яо-гийн (1939 онд төрсөн) "Арван үлгэр" нэртэй номоос "Эрэл", "Хэлгүй эхнэр", "Эргүүлэг" нэртэй бэсрэг туужуудыг хятад хэлнээс хөрвүүлэн хятад эхийнх нь хамт хэвлүүлсэн байна. "Эрэл" туужид Вань Жүн охин, түүнд нэгэн зэрэг дурласан ах дүү гурвын тухай сонирхолтой хийгээд гунигтай түүхийг өгүүлнэ. "Хэлгүй эхнэр" туужид сурвалжит баян Лиү Жин Ян болон түүний хосгүй үзэсгэлэнт хэлгүй эхнэр Фан Ий Ий, охин Сүүр нарын эмгэнэлт хувь заяаг сэтгэл хөдлөм, уран чадварлагаар дэлгэн үзүүлжээ. "Эргүүлэг" туужид амьдралын доргио донсолгоонд сэгсчүүлж, улс төрийн үймээн самууны хөлд үрэгдсэн Хө Мужигийн гэр бүлийн учрал хагацал, жаргал зовлон, ээдрээ будлианыг харуулдаг.

84(5Хят)

Я-11

/НУН-унш-3ш/

Б-24417-24418



УРЛАГ СУДЛАЛ



Оюунбадрах Б. **Төгөлдөр хуурын зохиолыг боловсруулах асуудал.** - УБ.: Мөрөөдлийн гурвалжин, 2016. -112х. -ISBN 978-99973-996-5-6.

Зохиогч энэхүү нэг сэдэвт бүтээлийн хүрээнд төгөлдөр хуурын зохиолыг боловсруулах асуудлыг өрнөдийн болон монголын судлаач, боловсруулагчдын бүтээлийн туршлагад тулгуурлан судалж С.Соронзонболдын төгөлдөр хуурын концертын гоцлол хувийг загвар болгон боловсруулжээ. Энэхүү бүтээл нь хөгжмийн зохиолыг боловсруулах асуудлыг шинжлэх ухааны үндэстэйгээр хөгжимчний тайлбарлалд тулгуурлан судалсан анхны бүтээл болж байгаагаараа, мөн зохиогч нь өөрийн хөгжимдсөн зохиолыг тусгайлан сонгож хөгжимчний боловсруулга хийсэн зэргээрээ шинэлэг болжээ.

85.3

Соёл урлагийн тайлбар толь I-Дүрслэх урлаг /Ред. Э.Сонинтогос.-УБ.:Сэлэнгэпресс,2016.-519х. -SBN978-99962-57-92-6.

(БСШУЯ,ШУТСан, МУСУИС, Соёл урлаг судлалын хүрээлэн)

Энэхүү номонд Төв азийн өндөрлөгт нүүдэллэн суурьшсан Монгол угсаатны урлахуйн нэршил, тайлбар, зүүсгэл хийгээд шинэ үеийн дүрслэх урлагт орж ирсэн нэр томьёо, орчин цагийн урлагийн зүтгэлтэн эрдэмтэн судлаач, эрх зүй, ном хэвлэл, үзэсгэлэн тэргүүтнийг нийгэм-түүх соёлын харилцаанд шинжлэн эрт эдүгээгийн баялаг уламжлалтай уран сайхны соёл дахь хэлбэр, хэв маяг, овор хийц, донж илэрхийлэл зэрэг бүхий урлахуйн арга ухааны цогц асуудлыг онол арга зүйгээр эрэмбэлэн багтаасан болно.

85.1

C-52

T-18290



Соёл урлагийн тайлбар толь II-Шашин соёл /Ред. Э.Сонинтогос. -УБ.: Сэлэнгэпресс,2016.-309х.-978-99973-73-84-7.(БСШУЯ,ШУТСан, МУСУИС, Соёл урлаг судлалын хүрээлэн)

Энэхүү тайлбар тольд нийт найман агуулгаар, 1230 толгой үгийг цагаан толгойн үсгийн дарааллын дагуу байршуулж, зан үйл тэргүүтэнд холбогдох 237 зураг нэрсийн хэлхээ зохион хамтатгав. Тайлбар толь нь хүмүүс, байгууллага, ном тогтмол хэвлэл, эрдэм шинжилгээний хурал, хууль тогтоомж, зан үйл, урсгал чиглэл, шашны сэдэвт урлагийн бүтээл гэсэн 8 агуулгын хүрээнд эдгээр эх сурвалжийг хэрэглэгдэхүүн болгон ашиглажээ.

85+86.35

C-52

T-18291

Соронзонболд С. Төгөлдөр хуур, найрал хөгжмийн концерт /Соль минор/: Хоёр гарт зориулсан хувь. -УБ.: Мөрөөдлийн гурвалжин, 2016. -43х.

Энэхүү концертыг хэрхэн хөгжимдсөн нь зохиогчийн “Хөгжмийн бүтээл” /2013/ цомогт бууж, хэрхэн боловсруулсан нь “Төгөлдөрхуурын зохиолыг боловсруулах асуудал” нэг сэдэвт бүтээлд /2 бүлэг/ бичигдэж, боловсруулалтын үр дүн нь энэхүү нот бичвэрээр илрэн гарч байгаа ажээ.

85.31

C-59

T-18433-18434



Уран барилга 30 секундэд: Уран барилгын хэв маягийн 50 сонгодог ойлголтыг хагас минутад багтаасан тайлбар /Эрхл. Эдвард Дэнисон; Орч. Б.Гэрлээ. -Анхны хэвлэл. -УБ.:Нэпко, 2016. -160х. -ISBN 978-99973-990-1-4.

Эртний Ромын уран барилгач, уран барилгын эцэг гэгдэх Марк Витрувий Поллионы дэвшүүлсэн хэвшмэл стандартын дагуу улс үндэстний энгийн орон байр, чулуугаар бүтээсэн гайхам байгууламжууд болон төрх байдлаа хувиргасан тэр л үеэс судалж эхлэх юм. Номын хоёрдугаар бүлэгт дээрх салбарын хөгжил цэцэглэлтийн үндэс болсон бүрдэл хэсгүүдийг тайлбарлана. Үүнд нуман хаалга, дам нуруу, багана төдийгүй бөмбөгөр

орой, хүнхэр адар, яс мод зэрэг арай орчин үеийн нарийн эдлэгдэхүүнүүд багтана. Ингээд уран барилгын онол практикийг гурав, дөрөвдүгээр бүлэгт тусгалаа. Зураг төсөлд зориулагдсан гутгаар бүлэгт уран барилгын үзэмж байдлыг өгүүлнэ. Энэ хэсэгт төлөвлөлт, огтлол, нүүрэн тал гэх мэт ухагдахууны чухал шинж болоод масштаб, тэгш хэм, алслалтыг таниулна. Харин дөрөвдүгээр бүлэгт уран барилгын хөгжилд нөлөөлсөн үндсэн онол, чиг хандлагуудыг хамрууллаа.

85.11я2

У-45

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Т-18464-18466

Уртын дууны хатан хаан /Ред. Э.Сонинтогос; Орч. С.Бэлгүдэй, Э.Содонтогос. - УБ.:Сэлэнгэпресс, 2016. -291х. -978-99962-64-69-6. (Норовбанзад сан, Монгол Улсын Соёл Урлагийн Их Сургууль, Өвөрмонголын Багшийн Их Сургууль)




Энэхүү номонд Монголын үе үеийн эрдэмтэн судлаачид, нийгэм соёлын шилдэг төлөөлөгчид, авьяаслаг шавь нарынх нь нандин дурсамжийг оруулсан. Эх орноо магтан дуулж, уртын дуугаа тэнгэрт тултал магтаж, их дуучинтай нэгэн цаг үед аж төрж, үнэн шудрага үгийг нь сонсож, уянгалаг хийгээд хүчирхэг хоолойг нь шүтэн бишрэгсэдийн чинхүү сэтгэлийн үгийг хэлхэн өгүүлсэн байна.

85.3

У-51

Т-18289



Цэвэгдорж В. **Монгол ардын гучин гурван дууны түүх оршвой** /Эмхт. Ц. Нямтөр; Хян. С.Соронзонболд. -УБ.: Амжа принтинг, 2016. -184х.

Энэхүү "Монгол ардын гучин гурван дууны түүх оршвой" номын онцлог нь дууны үг, аялгуу нот байхын хамт уг дууны түүхэн эх сурвалжийг тайлбарлан оруулснаараа чухал ач холбогдолтой юм. Уг номонд орсон нийт 33 дуунаас Арван тавны сар, Гандан-уул, Гандий мод, Дөрвөн уул, Өөрийн иутаг санагдана, Шар хад, Эрүү цагаан болжмор зэрэг байгалийн сэдвээр нэрлэгдсэн дуунууд нэлээд байна. Байгаль, уул усны нэрний цаана язгууртан хүний эрхэмсэг охин, Нар Хажидын сүмийп хөгжимчин, Төгс-Очир ханы эрх танхи гүнж, Богд гэгээний хатан, хожгор Цахарын ганц хүү, Балданцэрэн Дулам зэрэг нэртэй хүний зүстэй хүмүүс түүхэнд байсныг сурвалжлан гаргажээ. Мөн Ай нан-аа, Гоо жи нан аа да, Гуалингаа, Дүйнхор даа лам, Дүүриймаа, Зэс гуай, Сүнжидмаа, Сэндэр охин, Юндэн гөөгөө, Янжиндулам зэрэг гол баатрын нэрээр нэрлэгдсэн тодорхой эзэнтэй дуунууд байна. Түүнчлэн морины зүсээр нэрлэгдсэн Ганган хул, Дөрвөн настай бор, Молор хээр, Хонин жороо морь, Хулсан шарга зэрэг дуу зохиогдох болсон шалтгаан, болон түүхэн бодит хүмүүстэй хэрхэн холбоотой болох учир явдлыг судлан тодорхой өгүүлжээ.

85.3(1)

Ц-92

/НУН-унш-4, ГНОФ-3ш/


Б-24462-24464

ШАШИН СУДЛАЛ

Буддын шашин, соёлын тайлбар толь:/Ш.Чоймаа, Л.Тэрбиш, Д.Бүрнээ, Л.Чулуунбаатар; Эрхл. Н.Хавх; Хян. Л.Хүрэлбаатар, Т.Булган. -УБ.:Соёмбо, 2015. - ISBN 978-99973-78-26-2


"Буддын шашин, соёлын тайлбар толь" хэмээх энэхүү бүтээлд буддизмын сургаалын агуулгыг бүхэлд нь гаргахыг зориогүй агаад харин тэрхүү сургаалыг судлах, ойлгох, сурталчлахад зайлшгүй шаардагдах гол гол нэр томьёо, ухагдахуун ойлголтын утга

санаа, агуулгыг товч хураангуйлан тайлбарлахыг хичээсэн байна. Энэ толийг бичихдээ Данжуурын бүх нэр томьёог орчуулах тогтсон таалал болсон "Мэргэд гарахын орон" хэмээх алдарт толь бичгийн уг хэллэгийг авч хэрэглэжээ. "Тайлбар толь" дахь цагаан толгойн дарааллаар байрласан нэр томьёонд 10 ухааны орон, түүний дотроос дотоод ухаан буюу Бурханы шашны үзэл таалал, гүн ухааны нэр томьёо зонхилох байрыг эзэлнэ.



86.35я2 Дэвт.1. -590х. /НУН-унш-3,ГНОФ-3,Лав-1ш/
Б-69 Дэвт.2. -583х. /НУН-унш-3,ГНОФ-3,Лав-1ш/

Б-24564-24566
Б-24567-24569



Ламын гэгээний ов соёл Төв Ази болон Монголд: Олон улсын эрдэм шинжилгээний эмхтгэл /Эмхт. С.Дулам. -УБ.:Мөнхийн үсэг, 2014. -188х.

Эл бүтээлийг Монголын шашны зул, соён гэгээрүүлэгч, эрдэнэ бандида хутагт, номун хан Ламын гэгээн Лувсанданзанжанцаны /1639-1704/ түмэн өлзий гийсний 375 жилийн ойд зориулан зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийг эмхтгэн гаргажээ. Уг

хуралд тавьсан илтгэлийг бүрэн эхээр нь фото зургийн хамт оруулжээ.

86.35

Л-20

/ШУС-ХУС-2ш/

Qian Long da Zang jing / Тэнгэр тэтгэгчийн Ганжуур Данжуур/ Б-1-168. –Бээжин хот.,Дундад Улсын номын сангийн хэвлэлийн хороо, 2009. -ISBN 978-7-80663-465-3.

Хятад хэл дээр гарсан Ганжуур Данжуурын энэхүү зохиолыг 168 ботиор хэвлэн уншигчдын гарт хүргэж байна.

86.35+82

Q-11

Б. 1-16. Da cheng bo guo bu /”Билиг Барамид”-ийн аймаг. 16 боть,19 зохиол.

Б. 17-20.Da cheng bao ji bu/”Эрдэнэ давхарлага”-ын аймаг. 4 боть, 37 зохиол.

Б. 21-23.Da cheng da ji bu/”Их хөлгөний элдэв судрын чуулган”-ы аймаг. 3 боть, 26 зохиол.

Б. 24-28.Da cheng hua yan bu/”Олонхи бурхан”-ы аймаг. 5 боть, 26 зохиол.

Б.29-31. Da cheng nie ran bu/”Гаслангаас нөхчсөн”-ы аймаг. 3боть, 13 зохиол.

Б.32-41. Da cheng wu dab u wai chong yi jing/”Их хөлгөний бусад орчуулга”-ын аймаг. 10 боть, 250 зохиол (сүүлчийн хэсэгт тарнийн ном 70 гаруй зохиол бий.)

Б.42-48. Da cheng dan yi jing/”Их хөлгөний тусгаар орчуулга”-ын аймаг. 7боть,166 зохиол (сүүлчийн хэсэгт тарнийн ном 50 гаруй зохиол бий.)

Б.49-55. Xiao cheng a han bu/”Бага хөлгөн”-ий аймаг. 7 боть, 137 зохиол.

Б.56-58. Xiao cheng a dan yi jing/”Бага хөлгөний тусгаар орчуулга”-ын аймаг. 3 боть, 102 зохиол.

Б.59-66. Song yuan ru zang zhu da xiao cheng jing/”Сүн,Юаны Их Бага хөлгөн судар”-ын аймаг. 8 боть, 300 зохиол.

Б.67. Da cheng lv /”Их хөлгөний винай”/-ийн аймаг 1 боть, 25 зохиол.

Б.68-77. Xiao cheng lv /”Бага хөлгөний винай”-ийн аймаг 10 боть, 59 зохиол.

Б.78-88. Da cheng lun /”Их хөлгөн шастир”-ын аймаг 11 боть, 93 зохиол.


Б.89-104. Xiao cheng lun /”Бага хөлгөний шастир”-ын аймаг 16 боть, 37 зохиол.

Б.105. Song yuan xu ru zang zhu lun /”Сүн,Юаны шастир”-ын аймаг 1 боть, 22 зохиол.



Б. 106-110. Xi tu sheng xian zhuan ji /"Энэтхэг орны зохиол"-ын аймаг 5 боть, 147 зохиол.

Б.111-168. Cit u zhu shu /"Дундад орны зохиол"-ын аймаг 58 боть, 209 зохиол.



Хорин долоон онгодын буултыг тэмдэглэсэн тэмдэглэл /Бэлт. Д.Энхтайван. -УБ.: 2015. -399х. -ISBN 978-99973-75-55-1.

Бөөг сонирхон сонжигчийн энэхүү өдрийн тэмдэглэлд 27 буулт, 27 нэр (Онгодуудын энэ номонд зориулж өгсөн нэр) байгааг анзааран "27" хэмээх нэрийг энэ номондоо хайрлажээ. Бөөтэй анх уулзан өөрийн өнцгөөс харан бичсэн энэ тэмдэглэлээ яг л тэр хэвээр нь сайнтай муутай, сайхантай муухайтай нь уншигч таны гарт өргөж байна. Тэмдэглэлийн эзэн тэрээр шүлэг, дуу сэтгэл болоод Онгодын үгийг өөрийнхөөрөө

найруулан бичсэн болно.

86.3

Х-47

Б-24425-24426

Шашин шүтлэг 30 секунд: Шашин шүтлэгийн гүн гүнзгий 50 сонгодог ойлголтыг хагас минутад багтаасан тайлбар / Эрхл.Рассэл Рэ Маннинг; Орч.Б.Гэрлээ. -Анхны хэвлэл. -УБ.: Нэпко, 2016. -160х. -ISBN 978-99973-990-6-9



Өнөө үед шашин шүтлэг ахин дэлгэрч байна. Манай дэлхийн сая сая шүтлэгтнүүд шашин бурханаа тэргүүндээ залсаар ирсэн билээ. Шашин шүтлэг нь шашингүй үзэлтнүүдийн сануулж хэлснийг үл тоон түмэн олныг өөртөө татсаар. Шашны суртал нь дотроо олон салбарлахын сацуу буй бүхэн нь бидний хувьд содон сонихон учир ийн анхаарал татах нь дамжиггүй. Эл номд шашны тухай бус, түүний итгэл үнэмшлийн тухай өгүүлэх юм. Шашин шүтлэг гээч ухагдахууныг цор ганц оновчтой тодорхойлолтоор ойлгуулах нь учир дутагдалтай. Тодруулж хэлбэл, энэ номд өгүүлсэн хүн төрөлхтний 50 зүйл шүтлэгийн талаар мэдэж авснаар бид тухайн үндэсний өв соёл, балар эртний ёс заншил, домог хууч хийгээд шинэ үеийн шашин шүтлэгийн талаар тойм мэдлэгтэй болно.

86.2я2

Ш-37

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Т-18452-18454

ГҮН УХААН



Вольтер. **Кандид буюу өөдрөг үзэл** /Франц хэлнээс орч. Ц.Батбуян; Ред. Р.Энхбат. -УБ.: Монсудар, 2016. -186х. -ISBN 978-99973-1-296-9.

Вольтерын энэ романыг түүний бусад бүтээлийн хураангуй гэж хэлж болно... Түүний оюун ухаан яг дайны зэвсэг л гэсэн үг. Улс төрийн абсолютист дэглэмээс гадна шашны зүгээс бодол санааг хянах оролдлогын эсрэг зарласан оюун ухааны дайны үе ч гэж хэлж болох XVIII зууныг Францад "Вольтерын эрин" гэж нэрлэдэг билээ. Вольтер,

философи, утга зохиолын бүтээлүүдээрээ энэ үеийг тухайн үеийн бусад сэтгэгчийнхээс онцгой тод тамгалсан учирийн хүүнэрлэсэн биз.Энэ ном нь Монсударын "Утга зохиол" цувралын хоёр дахь ном юм.

87.22+84

В-71

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24522-24524

Жан ШиЧин. **Орчин үеийн Хятад дахь Күнзийн сургаалын хувь тавилан** /Ред. Р.Дарьхүү; Хятад хэлнээс орч. Б.Дулам. -УБ.: Урлах эрдэм, 2016. - 258х.

Күнзийн сургаал нь Хятадад 2000 гаруй жилийн хугацаанд дэлгэрч, тасралтгүй хөгжсөөр хүмүүсийн нийтээр дагаж мөрдөх итгэл үнэмшил болжээ. Күнзийн сургаалын хувь тавиланг 1840-1942, 1851-1864, 1861-1895, 1898, XX зууны өмнөх 10 жил гэсэн 5 үечлэлд хуваан авч үзсэн энэ номын агуулгыг өнгөц харвал Күнзийн сэтгэлгээ соёл юунд ч хэрэггүй мэт сэтгэгдэл уншигч танд төрж болох юм. Харин энэ номыг нухацтай уншвал өөрөөр хэлбэл номон доторх шүүмжлэлүүдийг сайтар эргэцүүлэн шүүн шинжилбэл Күнзийн сэтгэлгээ соёлын талаар бид илүү тодорхой зөв ойлголттой болох бололцоотой.

87.3

Ж-24

/НУН унш-4, ГНОФ-3, ШУС-ХУС-2ш/

T-18310-18312



Клайст Х.Ф. **Михаэль Коолхаас** / Герман хэлнээс орч. Д.Моононцагаан; Ред. Б.Төмөр, Б.Батцэцэг. -УБ.:Монсудар, 2016. -162х. -ISBN 978-99973-1-301-0.

Германы агуу сонгодог зохиолчдын нэг Хайнрих фон Клайстыг мэддэг хүн ховор. Гэтэл Клайст эдгээр зохиолчид дундаас хамгийн сонирхолтой нь шүү дээ! Уг зохиолын орчуулгын төслийг Гёте Институтын зүгээс санхүүжүүлснийг энд дурдах нь зүйтэй болов уу. 1810 онд анх хэвлэгдсэн “МИХАЭЛЬ КООЛХААС” туужийн тухай “Энэ зохиолыг би сүсэглэн биширч уншлаа” гэж Франц Кафка нэгэн захиандаа бичжээ. Юу юунаас илүү танил талаа эрхэмлэдэг улстөрчдөд хууртсан адууны худалдаачны өшөө авах гэсэн тэмцлийн түүх 200 жилийн дараа ч шинэ соргог хэвээр. Михаэль Коолхаас гэж хэн бэ? Хээл хахуульд автсан улсад шударга ёсыг тогтоохоор шийдсэн аймшиггүй хувьсгалч уу? Эсвэл зүгээр л нэг увайгүй террорист уу? Энэхүү асуулт дэлхийн уншигчдыг хоёр талцуулж маргалдуулсаар. Харин таны хариулт ямар байх бол?

87.22+84

К-47

/НУН-унш-4,ГНОФ-3ш/

Б-24519-24521

Отгонбаяр М. **Логик**: Сурах бичиг /Ред. Ц.Гомбосүрэн. -3 дахь хэвлэл. -УБ.:МУИС, 2016. -224х. -ISBN 978-99962-61-77-0.


Орчин цагт логик нь нэг талаар философийн танин мэдэхүйн онолтой, нөгөө талаар хэлний онол, математик, компьютерийн шинжлэх ухаантай холбоотойгоор олон шинэ чиглэлд хөгжиж,түүний онолын болон хэрэглээний ач холбогдол улам бүр өссөөр байна. “Математик логик”, “ символик логик” гэж нэрлэгддэг орчин үеийн логик бол өнөө цагийн сэтгэлгээний аргад улам бүр нөлөөлөх болсон нь логикийг зөв сэтгэхүйн тухай шинжлэх ухаан мөн гэж сургадаг уламжлалт логигоос ялгаатай болгож байна.Энэхүү сурах бичиг нь ерөнхий суурь багцын хүрээнд үзэж судлах Логикийн удиртгал хичээлийн үндсэн хэрэглэгдэхүүн болох юм.

87.4я73

О-53

/НУН-унш-7,ШУС-ХУС-5,ХЗС-10ш/

T-18406-18408



Рандерс Ж. **Даян дэлхийн тухай ирэх дөчин жилийн таамаглал 2052** /Ред.Д.Дэжидмаа.- УБ, 2016.- 361х.-ISBN 978-99973-45-99-8.



Дэлхий ирэх дөчин жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдөх вэ гэдгийг мэдэхийг бид мэдээж хүсдэг. Хэрэв бид тогтвортой ирээдүйг хүсвэл, үүний төлөө ирэх 40 жилд юу хийж чадах вэ гэдгийг бас мэдэхийг хүсдэг. Гэхдээ ирэх 40 жилд дэлхий ямар байхыг бид мэдэж чадах уу? Жорген Рандерс дэлхий 2052 онд ямар байхыг энэ номоороо хариулахыг хичээж байна. Жорген Рандерс нь 40 жилийн өмнө гарсан "Хөгжлийн Хязгаарууд" номны зохиогч нарын нэг бөгөөд уг судалгаа нь хүн төрөлхтөн зогсолтгүй хөгжлийнхөө явцад эх дэлхийн хязгаарлагдмал нөөц бололцоонд хэрхэн зохицон амьдрах талаарх асуудлыг хөндсөн байдаг. Тэрээр өөрийн туршлага дээр тулгуурлаж 2052 оны дэлхийн байдал болон дэлхий нийтийн цаашдын хандлага, төсөөлөл, урьдчилсан таамаглал зэргүүдийг энэхүү номондоо багтаасан байна.

87.22

P-22

/БУН-унш-3ш/

T-18313-18315

Соёмбо нэвтэрхий толь: Монгол ёс заншил, утга бэлгэдэл, хорио цээр /Ред. Э. Жаргалмаа. -УБ.:Соёмбо, 2015. -436х. -ISBN 978-99973-74-31-8.

Нүүдэлчин ард түмний ахуй, соёлын өвөрмөц онцлогоос болж тэдэнд төрийн хуулиас илүү ардын зан заншлын ёс буюу түмний хууль илүү хүчтэй, үр нөлөөтэй үйлчилдэг. Тиймээс мянга мянган он дамжин өвлөн уламжилсан ард түмнийхээ ёс заншлын ухааныг өдөр, цаг, хором, мөч бүр сурч судлан, амьдрал ахуй, харилцаандаа ёсчлон биелүүлж дагаж мөрдөх нь ялангуяа хүн болж төлөвшиж буй залуучуудад эрхэм билээ. Уг бүтээлд утга бэлгэдэл, хорио цээр, Тэнгэр шүтлэг, бэлгэдэл, Чингис хааныг дээдлэн шүтэх ёс, зан үйл, Одон зурхайн шүтлэг, бэлгэдэлтэй холбоотой ёс заншил, Монголчуудын газар эх, шүтлэг бэлгэдэл, Монгол ухаан, бэлгэдэл, Монгол хувцасны түүх, монгол урлал, урлаг, уламжлал, Монгол аж ахуйн ёс, Байгаль шинжин таних ухаан, Монголчуудын нүүдэллэх ёс заншил зэрэг ёс заншлын дээжээс толилуулж байна.

87.774(1)

C-52

/НУН-унш-3,ГНОФ-3,Лав-1ш/

T-18385-18387



Философи 30 секунд: Философийн сэтгэлгээний 50 сонгодог ойлголтыг хагас минутад багтаасан тайлбар /Эрхл. Барри Лоувэр; Орч. Б.Батчулуун. -Анхны хэвлэл. -УБ.: Нэпко, 2016. -160х. -ISBN 978-99973-990-8-3.

Юмс, үзэгдлийн гүнд байдаг асуудлын талаар эргэцүүлж, шинжлэх ухааны үндсийн тухай системт тайлбарыг хөгжүүлснээр "шинжлэх ухааны философи" үүсдэг. Ёс зүй, урлаг, шашин, математик, сэтгэл зүй, хэлний асуудлыг ч авч үздэг салбар бас бий. Аливаа судалгаа, оюуны үйл ажиллагаа нь юмс үзэгдлийн үндсэнд хүрэхийг хичээнэ. Философийн хамгийн ерөнхий салбар бол онтологи (юу оршин буйг авч үздэг онол [манайд хааяа "ахуйн тухай сургаал" гэж орчуулдаг. Орч.]), эпистемологи (оршин буй зүйлсийн талаар бид хэр зэрэг их зүйл мэдэж чадах тухай онол [танин мэдэхүйн онол]), этик (юуг хийж болох тухай сургаал [ёс зүй]) юм. Философчидийн янз бүрийн асуудал, байр суурь, парадокс бий болдог нь энэ номоос харагдах болно.

87я2

Ф-56

/НУН-унш-4,ГНОФ-3ш/

T-18455-18457



Чоймаа Ш. **Монгол ёс заншил, уламжлалт ухаанаа заан сургагч нарт тус дэм.** -УБ.:Соёмбо, 2015. -376х. -ISBN 978-99973-78-49-1.

Бид хийгээд бидний өвөг дээдэс хүн төрөлхтний нэг хэсэг төдийгүй монгол угсаатан билээ. Тиймийн тул бидний монголчууд дэлхийн хүн зоны зөв ёсыг эрхэмлэхийн хамт, монгол ёс заншил, хэл бичиг, соёл түүхээ өвлөн тээж, уламжлагчид гэдгээ гүнээ ухамсарлаж, өнгөрсөн ба ирээдүйн өмнө хүлээх хариуцлагаа олтгойлж үл болно. Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2010 оны 5 дугаар сарын 21-нд "Монголын уламжлалт сэтгэлгээ, арга билгийн ухааны үндэс" хичээлийг ЕБС-д албан ёсны хичээл болгон заах зарлиг гаргасан билээ. Иймд уг хичээлийг заагч, заалгагч хэн бүхэнд зүйл зүйлийн унших, лавлах ном хэрэгтэй бөгөөд мөнхүү тийм санал сэдлээр МУИС-ийн багш, доктор профессор Ш.Чоймаа энэхүү номоо бичиж нийтлүүлсэн байна.

87.774

Ч-75

/НУН-унш-4, ГНОФ-3ш/

Б-24465-24467

СЭТГЭЛ СУДЛАЛ

Батсайхан Б., Дэлгэржав М. **Зар сурталчилгааны сэтгэл судлал** /Ред. Ш.Батсүх, Д.Батхуяг, Б.Мөнхболор. -УБ.:Соёмбо, 2016. -435х. -ISBN 978-99962-75-65-4.

Хэрэглэгчийн шаардлага, хэрэгцээ, хүлээлтийг судалж, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээллийг сэтгэл зүйн үндэстэй боловсруулдаг хэрэглээний сэтгэл судлалын салбарыг зар сурталчилгааны сэтгэл судлал хэмээнэ. Орчин үед зар сурталчилгаа хүнийухамсар сэтгэцэд нөлөөлөх хүчтэй хэрэглээ болоод байна.

Иймээс сэтгэл судлал, зар сурталчилгаа хоёр салшгүй ойлголт болно. Зар сурталчилгааны сэтгэл судлал нь сурталчилж буй бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг зээмших, худалдаж авахад хэрэглэгчийг өдөөх зорилготой мэдээллийг боловсруулах бөгөөд зар сурталчилгааны сэтгэл зүйн үндэс нь сэтгэл зүйн үзэгдэл, зүй тогтолд тулгуурлан хэрэглэгчийг удирдах, түүнд нөлөөлөх үйл явц юм.


88.3

Б-34

/Цахим номын санд-1ш/



Дүэк С. **Хандлага:** Амжилтад хөтлөх шинэ сэтгэлзүй /Орч.Ред. Н.Жавхлан; Орч. Б.Төмөр. -УБ.:Адмон, 2016. -401х. -ISBN 978-99973-1-347-8.



Хүн амжилтад хүрэх эсэх нь дан ганц авьяас чадвараас хамаардаггүй, бас тухайн хүний сэтгэлийн хандлага ямар байна вэ гэдгээс ихээхэн хамаардаг болохыг энэхүү номд онолын үндэстэй, олон жишээ баримттайгаар тайлбарлажээ. Хүүхдийн ухаан, авьяас чадварыг магтаж сайшаах нь өөртөө итгэлтэй болгож, амжилтад хөтлөхгүйгээр барахгүй харин ч ахиж дэвшихэд нь саад болох магадлалтай. Зөв сэтгэлгээний ачаар бид хүүхдээ урамшуулж сурлагыг нь ахиулахаас гадна өөрсдийн хувийн амьдрал, ажил мэргэжилдээ ч хүссэн зорилгодоо хүрч чадна.

Сэтгэлийн хандлага зөв байхын хэрээр хүн сурч мэдэх хүсэл эрмэлзэлтэй, тэвчээртэй шаргуу байна. Харин эдгээр чанар нь амьдралын салбар бүрд гялалзсан амжилтад хүрэхийн үндэс суур нь юм.Удирдах ажилтан, багш, оюутан, судлаач, бизнес эрхлэгч, төрийн албан хаагч, олон нийт, Хүүхдээ амжилтад хүргэхийг хүссэн эцэг эхчүүдэд зориуллаа.

88.53

Д-74

/НУН-унш-4,ГНОФ-3,ШУС-НУС-1ш/

Б-24549-24551

Сарантуяа Г., Цогзолмаа Д. **Миннесотын бие хүний олон хэмжүүрт асуулга**: Аргын үүсэл хөгжил, Судалгаа авах арга зүй, Үр дүнг боловсруулах, тайлбарлах.- УБ.:Жиком пресс, 2016. -156х. - ISBN978-99973-84-9-7.



Энэхүү номонд сэтгэл судлалын практикт өргөн хэрэглэгддэг Миннесотын бие хүний олон хэмжүүрт асуулгын үүсэл, хөгжил, хувилбарууд болон судалгааг авахад анхаарах зүйлс, судалгааны заавар, асуулт хариултын хуудас, үр дүнг боловсруулах арга зүй зэрэг асуудлыг багтаасан. Сэтгэл зүйн мэргэжилтэн, оюутан судлаачдад зориулагдсан.

88

С-33

/НУФ-4, ГНОФ-3ш, НУС-10ш/

Т-18322-18324



Фишер Р., Юри В. **Зөвшилцөлд хүрэх урлаг**: Буулт хийлгүйгээр тохиролцоонд хүрэх нь /Орч. Б.Хүсэлбадрах; Хян. Б.Паттон. -УБ.: Монсудар, 2016. -218х. -ISBN: 978-99973-1-339-3.

Хувийн, ажил хэргийн асуудлаа шийдэх хэлцэл, тохиролцоо хийх үед бидэнд тохиролцоонд хүрэх ур чадвараа сайжруулах хэрэгцээ гардаг. Үүнд суралцах хамгийн зөв гараа бол “Зөвшилцөлд хүрэх урлаг” ном юм. Янз бүрийн түвшний хэлэлцээр, зөрчил шийдвэрлэл судалдаг Харвардын Хэлэлцээр Төслийн судалгааны ажилд суурилсан эл бүтээлд хувьдаа болон бизнестээ ашиглаж болох харилцан ашигтай тохиролцоонд хүрэх нийтлэг арга барилыг ойлгомжтой зааж өгчээ. Дэлхийн олон улс орон харилцан ашигтай хэлэлцээрт хүрэхэд, зөрчилдөөндөө хувьсгал хийхэд, олон улсын бэстсэллер болсон энэ ном туслах болно.

88.53

Ф-68

/НУН унш-4, НУС-1, ГНОФ-3ш/

Б-24546-24548

Чалдини Б. **Нөлөөлөл**: Ятгалгын сэтгэлзүй /Ред. Т.Ариунсанаа; Орч. Б.Хүсэлбадрах. -УБ.:Адмон, 2016. -309х. -ISBN 978-99973-1-340-9.



Ятгалгын тухай сонгодог бүтээл болох *Нөлөөлөл* ном хүмүүс ямар үед “За” гэж хэлдгийг сэтгэл судлалын үүднээс тайлбарлахын хамт энэ талаарх ойлголтуудыг амьдралд хэрхэн ашиглаж болох талаар өгүүлжээ. Доктор Роберт Чалдининь эрчимтэй тэлж буй нөлөөлөл, ятгалга судлалын салбарын дээд зэргийн мэргэжилтэн юм. Олны сайшаалыг хүртсэн энэхүү бүтээл түүний 35 жилийн бодит амьдрал дээрх судалгаа, гурван жилийн хүний авир байдлын талаарх сургалтын үр дүнд төржээ. Энэхүү номоос та авъяаслаг ятгагч болоход тань туслах зургаан зарчмыг сурахаас гадна, тэдгээрээс хэрхэн хамгаалахыг суралцана. Та ямар ч ажил мэргэжилтэй, юу ч хийдэг хүн байлаа гэсэн *Нөлөөлөл* номон дахь зарчмууд таныг гүнээ өөрчлөх ба амжилт руу тань хөтлөх болно.

88.53


Ч-16

/НУН-унш-4, ГНОФ-3, ШУС-НУС-1ш/

Б-24558-24560

ГАДААД ХЭЛ ДЭЭРХ НОМУУД

Connors R., Smith T. **How did that happen?** Holding people accountable for results the positive, principled way. –NY.: Portfolio, 2009. -252p. -ISBN 978-1-59184-258-3.



The economy crashes, the government misfires, businesses fail, leaders don't lead, managers don't manage, and people don't follow through, leaving us asking, "How did that happen?" Surprises caused by a lack of personal accountability plague almost every organization today, from the political arena to large and small businesses. How Did That Happen? offers a proven way to eliminate these nasty surprises, gain an unbeatable competitive edge, and enhance performance by holding others accountable the positive, principled way. As the experts on workplace accountability and the authors of The Oz Principle, Roger Connors and Tom Smith tackle the next crucial step everyone can take, whether working as a manager, supervisor, CEO, or individual performer: creating greater accountability in all the people on whom you depend.

65.290-2

C-74

/БС-1ш/



Connors R. and oth. **The OZ principle:** Getting results through individual and organizational accountability /Smith T., Hickman C. –NY.: Portfolio, 2004. -232p. -ISBN 978-1-59184-024-4.

Since it was originally published in 1994, The Oz Principle has sold nearly 600,000 copies and become the worldwide bible on accountability. Through its practical and invaluable advice, thousands of companies have learned just how vital personal and organizational accountability is for a company to achieve and maintain its best results. At the core of the authors' message is the idea that when people take personal ownership of their organization's goals and accept responsibility for their own performance, they become more invested and work at a higher level to ensure not only their own success, but everyone's. Now more than ever, The Oz Principle is vital to anyone charged with obtaining results. It is a must have, must read, and must apply classic business book.

65.290

C-74

/БС-1ш/



Kaufman R. **Uplifting service:** The proven path to delighting your customers, colleagues, and everyone else you meet. –Singapore: Evolve, 2012. -318p. – ISBN 978-981-07-1832-9.

New York Times bestselling author Ron Kaufman knows the answer to this question, and not only believes we can do it better, but shows us how. In Uplifting Service he takes you on a journey into a new world of service that is guided by fundamental principles and actionable models. After more than two decades helping leaders transform their service cultures, Kaufman has discovered that while each successful team is different, the architecture they apply to build an uplifting service culture is the same. In this New York Times, USA Today, and Amazon.com bestselling book, Kaufman lays out the steps you can take to build a sustainable culture that delivers outstanding service every day. He offers the tools and practices that have been proven effective in businesses, governments, communities, and homes; on every continent; and in many languages. Through perspective-changing insights and case studies, you will learn how the world's best performing companies have changed the game through service—and how you too can follow this proven path to an uplifting transformation.


65.290

K-24

/БС-2ш/

Leadership and self-deception: Getting out of the box. The Arbinger institute. -2nd ed. –Oakland: BK., 2010. -199p. -ISBN 978-1-57675-977-6.


Since its original publication in 2000, Leadership and Self-Deception has become a word-of-mouth phenomenon. Its sales continue to increase year after year, and the book's popularity has gone global, with editions now available in over twenty languages. This new edition has been revised throughout to make the story even more compelling. And drawing on the extensive correspondence the authors have received over the years, they have added a section that outlines the many ways that readers have been using Leadership and Self-Deception to improve their lives and workplaces—areas such as team building, conflict resolution, and personal growth and development, to name a few. Read this extraordinary book and discover what millions already have learned—how to consistently tap into an innate ability that dramatically improves both your results and your relationships.



65.290

L-50

/БС-1ш/



Lewis D. Mills G.Riley. **The pin drop principle:** Captivate, influence and communicate better using the time-tested methods of professional performers. –NY.: Jossey-Bass, 2012. -255p. -ISBN 978-1-118-28919-8.

The Pin Drop Principle is a step-by-step master class for anyone wishing to become a more confident and credible communicator. Lewis and Mills believe all business professionals ought to deliver their message in such an engaging way that one could literally hear a pin drop when they speak. The secret to doing so comes from an unusual world: professional acting. By activating "objective" and "intention"—the main tools of actors (and great communicators) business people can give their messages meaning and relevance, so the recipients walk away knowing why the message is important and what is in it for them. The Pin Drop Principle is an accessible resource for anyone who routinely needs to present ideas to large or small groups, convey feedback effectively, conduct difficult conversations, and persuade others.


65

L-63

/БС-1ш/

Namsrai Kh. **Universal Formulas in integral and Fractional Differential Calculus.** -USA.: World Scientific Publishing, 2016. -279p. -ISBN 978-981-4675-59-8.


This reference book presents unique and traditional analytic calculations, and features more than a hundred universal formulas where one can calculate by hand enormous numbers of definite integrals, fractional derivatives and inverse operators. Despite the great success of numerical calculations due to computer technology, analytical calculations still play a vital role in the study of new, as yet unexplored, areas of mathematics, physics and other branches of sciences. Readers, including non-specialists, can obtain themselves universal formulas and define new special functions in integral and series representations by using the methods expounded in this book. This applies to anyone utilizing analytical calculations in their studies.



22.161.1

N-20

/БУН-уНШ-1,ГФ-1ш/



The global employer: Focus on trade unions and works councils. -Baker & McKenzie, 2014. -455p.

At Baker & McKenzie, we understand that business success requires legally sound, strategically savvy labor and employment policies and practices. With 76 offices in 47 countries, Baker & McKenzie has an unparalleled global reach to serve the needs of employers. Our Global Labor, Employment & Employee Benefits Practice Group includes more than 500 lawyers strategically positioned around the globe. We help employers navigate and understand the ever-changing requirements necessary to comply with local and international laws and customs, prevent unwanted employee issues from arising, and continuously adapt to the realities of worker issues in an intensely competitive global economy.

65.24

T-44

/БС-1ш/